МАК
МОНГОЛЫН АЛТ
(МАК) ХХК

# МАК АРАНЖИН ЗЭС ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН НУТАГТ ОРШИХ ЦАГААН СУВАРГЫН КАТОДЫН ЗЭСИЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**(Аж ахуйн регистрийн дугаар: 5849187)**



# 2025

# АГУУЛГА


**БҮЛЭГ 1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 8**

**1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ ........ 8**

**1.2 ГЕОЛОГИЙН НӨӨЦ ........ 8**

**1.3 ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ ........ 9**

**1.4 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ ........ 10**

**1.5 ИСЭЛДСЭН ХҮДРИЙГ ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ........ 10**

**1.6 КАТОДЫН ЗЭС ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ ........ 12**

**1.7 ДЭД БҮТЭЦ ........ 13**

**БҮЛЭГ 2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 14**

**2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ ........ 14**

**2.2 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ........ 15**

2.2.1 Зам талбайн тоосжилтыг бууруулах үйл ажиллагаа ........ 18

2.2.2 Үйлдвэрийн дотоод шороон зам засвар ........ 18

2.2.3 Агаарын чанарын хэмжилт ........ 20

**2.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ........ 21**

2.3.1 Ус ашиглалтын мэдээг дотоод системд бүртгэх ........ 26

2.3.2 Усны тоолуурын баталгаажуулалт, ус ашигласны төлбөр ........ 26

2.3.3 Усны менежментийн журмын хэрэгжилт ........ 27

2.3.4 Ус дамжуулах хоолой засвар ........ 29

2.3.5 Гадаргын ус цуглуулах цөөрөм ........ 29

2.3.6 Усны менежментийн сургалт ........ 31

2.3.7 Гүний усны мониторинг ........ 32

2.3.8 Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж ........ 32

2.3.9 Хаягдал усны дүгнэлт ........ 33

**2.4 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ........ 35**

2.4.1 Газар хөндөх, шимт хөрс хуулах хадгалахтай холбоотой журам ..... 38
2.4.2 Шимт хөрсний хуулалт ..... 38
2.4.3 Шимт хөрсний хадгалалт ..... 39
2.4.4 Шатах, тослох материалын асгаралтад хяналт тавих ..... 39
2.4.5 Асгаралтын иж бүрдэл ..... 42
2.4.6 Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах сургалт ..... 42
2.4.7 Хог хаягдлыг хөрсөнд нэвчихээс сэргийлэх ..... 43

**2.5 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ..... 44**

2.5.1 Ургамлын бүртгэл ..... 45
2.5.2 Тэрбум мод үндэсний хөдөлгөөн ..... 46
2.5.3 Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ ..... 47

**2.6 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ..... 48**

2.6.1 Ан амьтны үзэгдэл ..... 49
2.6.2 Зэрлэг ан, амьтны анхааруулах тэмдэг ..... 50

**БҮЛЭГ 3 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 51**

**БҮЛЭГ 4 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 52**

4.1.1 Мод ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ..... 52

**БҮЛЭГ 5 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 53**

5.1.1 Зэрлэг ан, амьтны хяналтын камер ..... 54

**БҮЛЭГ 6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 55**

**БҮЛЭГ 7 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 56**

**БҮЛЭГ 8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 57**

8.1.1 Гал түймэртэй тэмцэх бүтэц орон тоог батлуулж ажиллуулах, Техник, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх ..... 8-59
8.1.2 Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлэх ..... 8-59
8.1.3 Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт ..... 8-59
8.1.4 Далан, шуудуу татах техникийн бэлэн байдлыг хангах ..... 8-60
8.1.5 Анхан шатны тусламж үйлчилгээний сургалт зохион байгуулах ..... 8-60
8.1.6 Газардуулгын хэмжилт хийлгэх ..... 8-61

8.1.7 Аюулгүй ажиллагааны зааварчилгаа ....8-61
8.1.8 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ....8-61
**БҮЛЭГ 9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....62**
9.1.1 Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах ....64
9.1.2 Дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх ....64
9.1.3 Хог хаягдлын нэгдсэн цэгийн төлөвлөгөө гаргах ....65
9.1.4 Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг гэрээт байгууллагад нийлүүлэх ....65
9.1.5 Хоол хүнсний үлдэгдлээр бордоо хийх ....67
9.1.6 Бусад хог хаягдлыг устгах ....68
9.1.7 Төслийн талбайн эргэн тойронд нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах ....68
9.1.8 Аюултай хог хаягдал устгуулах ....68
9.1.9 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгуулах ....69
**БҮЛЭГ 10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ....72**
10.1.1 Цаг уурын хяналт шинжилгээ ....79
10.1.2 Дуу чимээний хяналт шинжилгээ ....84
10.1.3 Агаарын чанарын хяналт шинжилгээ ....86
10.1.4 Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ ....88
10.1.5 Усан орчны хяналт шинжилгээ ....92
10.1.6 Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээ ....95
10.1.7 Амьтны аймгийн шинжилгээ ....98
**БҮЛЭГ 11 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....103**
11.1.1 Байгаль орчны холбогдолтой журмууд ....104
11.1.2 Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ....105
11.1.3 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд ....105
**БҮЛЭГ 12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ....106**

***Хүснэгтийн жагсаалт***

Хүснэгт 1-1. Исэлдсэн хүдрийн геологийн нийт нөөц ....9
Хүснэгт 2-1. БОМТ-ний зардлын хураангуй....14
Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ....15
Хүснэгт 2-3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ....21
Хүснэгт 2-4. Ус ашиглах гэрээ ....25

Хүснэгт 2-5. Шүүрлийн ус ашиглалтын мэдээлэл ... 26
Хүснэгт 2-6. Усан хангамжийн худгууд ... 26
Хүснэгт 2-7. Үерийн ус цуглуулах цөөрмүүдийн ерөнхий мэдээлэл ... 29
Хүснэгт 2-8. Цэвэрлэх байгууламжийн мэдээлэл ... 32
Хүснэгт 2-9. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ... 35
Хүснэгт 2-10. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ... 44
Хүснэгт 2-11. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт ... 48
Хүснэгт 2-12. Ан амьтны үзэгдэл мэдээг дотоод сүлжээний бүртгэл ... 49
Хүснэгт 3-1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ... 51
Хүснэгт 4-1. Ногоон байгууламжийн төлөвлөгөө ... 52
Хүснэгт 5-1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ... 53
Хүснэгт 7-1. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 56
Хүснэгт 8-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ... 57
Хүснэгт 9-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ... 63
Хүснэгт 10-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ... 73
Хүснэгт 10-2. Орчны хяналт мониторингийн цэгүүдийн тайлбар ... 77
Хүснэгт 10-3. Төслийн цаг уурын станцын байрлал ... 79
Хүснэгт 10-4. Сарын дундаж агаарын температур ... 80
Хүснэгт 10-5. Сарын нийлбэр хур тунадас ... 82
Хүснэгт 10-6. Агаарын чийгшлийн үзүүлэлт ... 83
Хүснэгт 10-7. Салхины дундаж хурд ... 83
Хүснэгт 10-8. Төслийн дуу шуугианы хяналт мониторингийн цэгүүд ... 84
Хүснэгт 10-9. Дуу чимээний хэмжилтийн үр дүн ... 85
Хүснэгт 10-10. Агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд ... 86
Хүснэгт 10-11. Хөрсний хяналтын цэгүүд ... 88
Хүснэгт 10-12. Төслийн унд ахуйн усны цэгүүд ... 92
Хүснэгт 10-13. Нарангийн хоолойн хяналтын цооногууд ... 95
Хүснэгт 10-14. Цооногуудын статик түвшний хэмжилтийн үр дүн ... 95
Хүснэгт 10-15 Ургамлан нөмрөгийн хяналт мониторингийн цэгүүд ... 95
Хүснэгт 10-16. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт ... 99
Хүснэгт 10-17. Бүртгэгдсэн мөлхөгчдийн зүйлийн жагсаалт ... 100
Хүснэгт 10-18. Орчны хяналт шинжилгээний үед бүртгэгдсэн шувуудын жагсаалт ... 101
Хүснэгт 11-1. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө. ... 103
Хүснэгт 12-1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө. ... 106

***Зургийн жагсаалт***

Зураг 2-1. “МАЗ” уурхайн зам усалгаа ... 18
Зураг 2-2. Төслийн талбай дах авто замын тэмдэг тэмдэглэгээний байршил ... 19
Зураг 2-3. Хурдны хязгаар, зогсоолын тэмдэг ... 19
Зураг 2-4. Агаарын чанарын хэмжилт ... 20
Зураг 2-5. Галба өөш долоодын говийн сав газрын захиргаанаас ирсэн хяналт шалгалт ... 25
Зураг 2-6. Ус ашиглалтын мэдээг ERP системд хөтөлсөн байдал ... 26
Зураг 2-7. Усны тоолуур суурилалт ... 26
Зураг 2-8. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ ... 27
Зураг 2-9. Усны төлбөр төлсөн баримт ... 27
Зураг 2-10. Усны менежментийн журам ... 28
Зураг 2-11. Нийт ажилчдын эрх, үүрэг ... 28
Зураг 2-12. Ус дамжуулах хоолой угсрах ажил ... 29
Зураг 2-13. Ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж ... 29
Зураг 2-14. Үерийн ус хуримтлуулах цөөрөм ... 30
Зураг 2-15. Дэлхийн усны өдрийн ханын самбар ... 31
Зураг 2-16. Усны менежментийн сургалтын материал ... 32
Зураг 2-17. Усны түвшин хэмжилт ... 32
Зураг 2-18. Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн зураг төсөл ... 33
Зураг 2-19. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ ... 34
Зураг 2-20. Хаягдал усны төлбөр төлсөн баримт ... 34
Зураг 2-21. Газар хөндөх зөвшөөрлийн хуудас ... 38
Зураг 2-22. Овоолгуудын тэмдэг, тэмдэглэгээ ... 39
Зураг 2-23.Машин техникийн зогсоол болон ЗҮТ-ийн машины зогсоол ... 40
Зураг 2-24. Асгаралтаас урьдчилсан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, тайлагнах үйл явцын нарийвчилсан зураглал ... 40
Зураг 2-25. Уурхайн талбайд байрлуулсан асгаралтын иж бүрдэл ... 42
Зураг 2-26. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах сургалт ... 43
Зураг 2-27. Төслийн талбайд байрлуулсан хогийн сав ... 43
*Зураг 2-28. Улаангоёо бүртгэгдсэн байршил* ... 45
*Зураг 2-29. 2025 онд ургасан Улаангоёо/* ... 46
Зураг 2-30. 2025 онд тарьж суулгасан мод /10-р сарын байдлаар/ ... 46
Зураг 2-31. Засвар үйлчилгээний төв ... 47
Зураг 2-32. Газар хөндөх зөвшөөрлийн хуудас ... 49
Зураг 2-33. Зам дагуух ан амьтны тэмдэг ... 50
Зураг 3-1. Улаан шавар олборлох талбай ... 51
Зураг 4-1 Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил ... 52

Зураг 5-1 Хөдөлгөөн мэдрэгчтэй камер ..... 54
Зураг 5-2 Ганзага ууланд гаргаж буй уст цэгийн өрөмдлөгийн ажил ..... 54
*Зураг 7-1 Ажилчдад орсон санамсаргүй олдворын үеийн авах арга хэмжээний тухай сургалт* ..... 56
Зураг 8-1. Түр оффис галын булан ..... 8-59
Зураг 8-2. Төслийн барилга, угсралтын ажлын явц ..... 8-60
Зураг 8-3. Үерийн далангийн урд хэсэг ..... 8-60
Зураг 8-4. Анхны тусламжийн сургалт ..... 8-60
Зураг 8-5 Үйлдвэрийн барилга угсралтын үйл явц ..... 8-61
Зураг 8-6 ХАБЭА-н зааварчилгааны бүртгэл ..... 8-61
Зураг 9-1. Төслийн талбайд байршуулсан хогийн савнууд ..... 64
Зураг 9-2. Дахин боловсруулах хаягдлыг түр хадгалах цэг ..... 65
Зураг 9-3. Хог хаягдлын цэгийн төлөвлөлт ..... 65
Зураг 9-4. “Төвшин сайхан мөнх” НҮТББ-тай байгуулсан гэрээ ..... 66
*Зураг 9-5. Хог хаягдлыг тээвэрлэх, устгах дараалал* ..... 66
*Зураг 9-6. Туршилтанд ашигласан хүнсий үлдэгдэл материал* ..... 68
Зураг 9-7. Хог хаягдлын түр хадгалах цэг ..... 68
Зураг 9-8. Орчны цэвэрлэгээ ..... 68
Зураг 9-9. Аюултай хог хаягдлын гэрээ ..... 69
Зураг 9-10. Эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээ ..... 70
Зураг 9-11. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгсөн акт ..... 71
Зураг 9-12. Эмнэлгийн хог хаягдал түр хадгалах цэг ..... 71
Зураг  10-1. Сар бүрийн агаарын температур ..... 82
Зураг 10-2. Дорноговь аймгийн УЦУОШГ-с ирүүлсэн агааын чанарын шинжилгээний хариу ..... 88
Зураг 11-1. Байгаль орчны холбогдолтой мөрдөгдөж буй журмууд ..... 104
Зураг 11-2. Анхан шатны тусламжийн нэгж ..... 105
Зураг 11-3. Бүх нийтийн мод тарих өдрөөр тарьсан мод ..... 105
*Зураг 12-1. Мандах сумын Алхан тээг багийн иргэдийн нийтийн хурал* ..... 107

***Графикын жагсаалт***

График 10-1. Агаарын дулаан хүйтний сарын явц ..... 81
График 10-2. Сарын нийлбэр хур тунадасны явц ..... 82
График 10-3. Салхины чиглэлийн давтагдал 3-9-р сар ..... 84

# БҮЛЭГ 1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

МАК Аранжин зэс ХХК-ийн Цагаан суваргын орд ашиглах төсөл нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт MV-017535 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан суварга нэртэй талбайгаас 3.5 км зайд буюу MV-009630 Сэрвэнсухайт нэртэй талбайн зүүн хойно байгуулагдах ба Улаанбаатар хотоос 560 км, Сайншанд хотоос баруун урагш 220 км, Мандах сумын төвөөс урагш 55 км, Чойр хотоос урагш 280 км, түүнчлэн Оюутолгойн уурхайгаас зүүн хойш 150 гаруй км, Таван толгойн уурхайгаас мөн адил чигт 250 км зайд, тус тус байрлана.




*Зураг 1-1. Төслийн талбайн байршил*

"Монголын Алт" ХХК-ийн эзэмшлийн MV-009630, MV-017535, MV-017541 ашиглалтын тусгай зөвшөөрлүүд бүхий Сэрвэнсухайт, Цагаан суварга, Түмэн Өлзий уул талбайнуудад хамаарах зэс-молибдены сульфидын хүдрийг олборлох явцад дагалдан гарах исэлдсэн хүдрийг үүсмэл хуримтлал овоолгод байршуулж шүлтгүйжүүлэлт–хандлалт– электролизын технологиор боловсруулан Катодын-Зэс үйлдвэрлэнэ.

## 1.2 ГЕОЛОГИЙН НӨӨЦ

Цагаан суваргын катодын зэсийн SXEW үйлдвэрийг зэсийн исэлдсэн хүдрээр хангах үндсэн орд болох MV-009630 Сэрвэнсухайт талбайд хамаарах Цагаан суварга ордын исэлдсэн

хүдрийн нийт (A+B) нөөцийг 0.45%-ийн дундаж агуулгатай 76,535.28тн металл зэс агуулсан 16.84 сая.тонноор, Түмэн Өлзий Уул талбайд хамаарах 2 ба 6-р хүдэржсэн хэсгүүдийн нийт баттай, бодитой (A+B) нөөцийг дотор 0.30%-ийн дундаж агуулгатай 32,507.0 тн металл зэс агуулсан 10.53 сая.тн-оор, MV-017535 Цагаан суварга талбайд хамаарах 3-р хүдэржсэн хэсгийн нийт баттай, бодитой (A+B) нөөцийг дотор 0.24%-ийн дундаж агуулгатай 2,567.0 тн металл зэс агуулсан 1.07 сая.тн исэлдсэн хүдрийн геологийн нөөц тус тус тогтоосон ба нийт исэлдсэн хүдрийн геологийн нөөц 28.44 сая.тн байна.

*Хүснэгт 1-1. Исэлдсэн хүдрийн геологийн нийт нөөц*

| № | Орд, хүдэржсэн хэсгүүд | Лицензийн дугаар | Геологийн нөөц, сая.тн | Агуулга, % | Ерөнхий зэс, тн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цагаансуваргын орд | MV-009630 | 16.84 | 0.454 | 76,535.28 |
| 2 | 2-р хүдэржсэн хэсэг | MV-17541 | 2.91 | 0.274 | 7,984.0 |
| 3 | 6-р хүдэржсэн хэсэг | | 7.62 | 0.322 | 24,523.00 |
| 4 | 3-р хүдэржсэн хэсэг | MV-17535 | 1.07 | 0.240 | 2,567.00 |
| 5 | Орд болон хүдэржсэн хэсгүүдийн нийт геологийн нөөц | | 28.44 | 0.392 | 111,609.28 |

## 1.3 ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

Цагаан суваргын катодын-зэсийн үйлдвэр төслийн үндсэн үзүүлэлт болох исэлдсэн хүдрийн нөөц, баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт, дэд бүтэц зэргийг нэгтгэж тооцон ТЭЗҮ-г боловсруулан бөгөөд тэдгээр үндсэн үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд үзүүлэв.

| № | Үзүүлэлт | Геологийн нөөц, сая.тн | Агуулга, % | Ерөнхий зэс, тн |
|---|---|---|---|---|
| ***Ерөнхий мэдээлэл*** | | | | |
| 1 | Исэлдсэн хүдэр нийлүүлэх ашиглалтын тусгай тусгай зөвшөөрөл бүхий талбайнууд | | | Сэрвэн сухайт (MV-009630), Түмэн Өлзий Уул (MV-017541), Цагаансуварга (MV-017535) |
| 2 | Ашигт малтмалын төрөл | | | Зэс |
| ***Геологийн нөөц*** | | | | |
| *3* | MV-009630 талбайд хамаарах нөөц | Баттай нөөц (А зэргээр) | сая.тн | 12.18 |
| | | Бодитой нөөц (В зэргээр) | сая.тн | 2.9 |
| | | **Ордын нийт нөөц (A+B)** | сая.тн | 15.16 |
| | | Овоолгод | сая.тн | 1.68 |
| | | Нийт | сая.тн | 16.84 |
| *4* | MV-017535 талбайд хамаарах нөөц | Баттай нөөц (А зэргээр) | сая.тн | 0.76 |
| | | Бодитой нөөц (В зэргээр) | сая.тн | 0.30 |

| № | Үзүүлэлт | Геологийн нөөц, сая.тн | Агуулга, % | Ерөнхий зэс, тн |
|---|---|---|---|---|
| | | **Ордын нийт нөөц (A+B)** | сая.тн | 1.07 |
| 5 | MV-017541 талбайд хамаарах нөөц | Баттай нөөц (А зэргээр) | сая.тн | 8.22 |
| | | Бодитой нөөц (В зэргээр) | сая.тн | 2.31 |
| | | **Ордын нийт нөөц (A+B)** | сая.тн | 10.53 |
| 6 | **Бүгд** | **Ордын нийт нөөц (A+B)** | сая.тн | 28.44 |
| ***Исэлдсэн хүдрийн ачилт, тээвэрлэлтэд ажиллах тоног төхөөрөмж*** | | | | |
| 7 | Утгуурт ачигч /LW1200KN/, 6.5м3 | | ш | 1 |
| 8 | Автосамосвал /МТ-86/, 60 тн | | ш | 4 |
| 9 | Бульдозер /Shantui SD22/ | | ш | 2 |
| ***Ажиллах горим*** | | | | |
| 10 | Жилд ажиллах хоногийн тоо | | хоног | 350 |
| 11 | Ээлжийн тоо | | ээлж | 2 |
| 12 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | | цаг | 12 |
| 13 | Нийт ажиллагсдын тоо | | хүн | 295 |

## 1.4 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Эхний ээлжид исэлдсэн хүдрийн овоолгод хураагдаад буй 1.68 сая.тн хүдрийг, дараа нь уурхайн олборлолтын хаягдал бохирдол тооцсоноор Сэрвэнсухайт талбайд хамаарах 15.58 сая.тн исэлдсэн хүдрийг уурхайгаас олборлон овоолгод байршуулан ашиглах бол төслийн 10 дахь жилээс Цагаан суварга, Түмэн Өлзий Уул нэртэй талбайнуудад хамаарах 2, 6, 3-р хүдэржсэн хэсгүүдээс олборлон нийлүүлэх 10.55 сая.тн исэлдсэн хүдрийг овоолон уусгах талбайд байршуулж, ингэснээр нийт 27.82 сая.тн исэлдсэн хүдрээс 13 жилийн хугацаанд 71,156.2 тн Катодын-Зэс үйлдвэрлэнэ.

## 1.5 ИСЭЛДСЭН ХҮДРИЙГ ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**MV-009630 Сэрвэнсухайтын талбай, Цагаансуварга орд I, II биетийн ашиглалт, уурхайн хүрээ:**

2010-2011 онд Австралийн "Coffey Mining" компани Цагаан суваргын ордод нарийвчилсан ТЭЗҮийг боловсруулсан бөгөөд хүдэр дэх зэсийн захын агуулгыг 0.20%-аар тооцож ил уурхайн хилийг тогтоон олборлох сульфидын хүдрийн хэмжээг +675 мийн түвшнээс дээш 212.8 сая.тн хүдэр, хүдэр дэх зэс 1,178 мян.тн, молибден 40 мян.тн байхаар тооцжээ. Ил уурхайг 3 үе шаттайгаар ашиглахаар төсөлд тусгасан байна.




*Зураг 1-2. Ил уурхайн 3-н хэмжээст загвар*

**MV-017541 Түмэн Өлзий Уул нэртэй талбайд хамаарах 2, 6-р хүдэржсэн хэсэг, биетүүдийн ашиглалт, уурхай хүрээ:**

2, 6-р хүдэржсэн хэсгүүд нь хэд хэдэн жижиг уурхай үүсэх бөгөөд олборлосон исэлдсэн хүдрийг олборлон ил уурхайн дэргэд гадаад овоолгод тусад нь байршуулна.



*Зураг 1-3. 6-р хүдэржсэн хэсгийн хүдрийн биетүүд, ил уурхайн дизайн*




*Зураг 1-4. 2-р хүдэржсэн хэсгийн исэлдсэн хүдрийг ашиглах уурхай доторх зэсийн агуулгын блок загвар*

3-р хүдэржсэн хэсгийн ил уурхайгаас 0.33 сая.тн хөрс олборлон зайлуулах бөгөөд 15 м гүнтэй ил уурхай үүсэх тул уурхайд газрын доорх ус ихээр орж ирэх магадлал бага, ашиглахад маш энгийн, ямар нэгэн хүндрэлгүй байхаар байна.

## 1.6 КАТОДЫН ЗЭС ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ

Хүдэр бэлтгэх хэсгийн технологийн сонголт: Цагаан суваргын орд газрыг түшиглэн байгуулагдах Катодын-Зэс үйлдвэрлэх SXEW үйлдвэрийн технологийг оновчтой сонгох, эдийн засгийн үр ашигтай байдал, найдвартай ажиллагаа, зэс авалт өндөр байх зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж нэлээдгүй олон тооцоо, судалгааны ажлуудыг хийсэн байдаг бөгөөд эдгээрээс технологи, зэс авалт, төслийн үр ашиг чухал нөлөөтэй шийдлүүдийг доор дурдав. Үүнд:

- Австралийн Молопо NL компани 1997 онд үйлдвэрийн урьдчилсан үнэлгээ хийхдээ технологийн схемд хүдэр бэлтгэх, бутлах дамжлагагүй байхгүй буюу хүдрийг бутлан нэгэн жигд ширхэглэлтэй болгохгүйгээр шууд нуруулдан овоолго үүсгэх технологийг сонгосон байдаг.
- 2008 онд Акер Солюшин компани исэлдсэн хүдрийг ашиглах ТЭЗҮ боловсруулахдаа анхдагч хүдрийг 40 мм хүртэл буталж овоолгод стакераар тавих, тэгэхдээ хүдрийг барбанд хүхрийн хүчлийн уусмалаар норгож тавих хувилбарыг авч үзсэн байдаг.

Цагаан суваргын Катодын-Зэс боловсруулах үйлдвэрийн хүдэр бэлтгэх хэсгийн технологийн сонголтыг хийхдээ хүдрийг -40 мм хүртэл бутлан овоолго үүсгэх технологийг ашиглана.

Үйлдвэрийн үндсэн технологийн сонголт:

- Нуруулдан уусгах талбай – Уусгалтын хэсэг нь овоолгын уусгалт (Dump) байх ба зэсийг шимт уусмалд шилжүүлж түүнийгээ шимт уусмалын санд хуримтлуулна.
- Уусмалын цөөрөм – SX цехийг тэжээх уусмалын сан
- SX цех буюу хандлах цех – Хандлалтын хэсэг нь үндсэн хандлагч (холигч-тунаагч), давтан хандлагч (холигч-тунаагч), угаагч хандлагч (холигч-тунаагч), урвуу хандлагч (холигч-тунаагч) ашиглана.
- EW цех буюу цахилгаан химийн цех – Цахилгаан химийн хэсгийн шат нь хандлах дамжлагаас ирсэн баян электролитийг шүүлтүүрээр шүүн бохирдлоос цэвэрлэж электролизын баннуудад жигд хуваарилан тогтмол гүйдэл өгнө.

## 1.7 ДЭД БҮТЭЦ

Катодын зэсийн үйлдвэр нь Цагаан суваргын үндсэн ил уурхайн талбайд байгуулагдах тул уурхайн гол барилга байгууламжууд буюу засвар үйлчилгээний төв, түлшний агуулах, түгээх байр зэргийг ашиглана.

**Үйлдвэрийн байр -** “Цагаан суваргын Катодын-Зэсийн Үйлдвэр”-ийн үндсэн байр нь 102 м урт, 54 м өргөн, 5,510 $м^2$ талбай бүхий 12.5 м өндөр барилга байна. Байгууламжийн суурийг БНХАУ-ын Энфи компанийн зураг, заавրын дагуу Монголын Алт (МАК) ХХК цутгах бөгөөд үйлдвэрийн дамжлага, тоног төхөөрөмжийн угсралт, зүгшрүүлэлтийн ажлыг Энфи компани хийж гүйцэтгэнэ.

**Үйлдвэрийн захиргаа удирдлагын байр -** Үйлдвэрийн захиргаа удирдлагын үндсэн байр нь 40 м урт, 20 м өргөн, 3.5 м өндөр байхаар төлөвлөсөн ба тухайн ажлын байранд үйлдвэрийн дарга, ИТА-ууд, эдийн засагч, нягтлан, компьютерын сүлжээний инженер гэх мэт албан тушаалтнууд суух бөгөөд уг байртай зэрэгцүүлэн ажилчдын ээлж солилцох нарядын өрөө, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө болон үйлдвэрийн цайны газрыг зэрэгцүүлэн байгуулахаар төлөвлөсөн.

**Хүхрийн хүчлийн агуулах -** Үйлдвэр нь жилд ойролцоогоор 48 тн 93%-ийн концентраттай хүхрийн хүчил хэрэглэх ба хүхрийн хүчлийг IMO-1 буюу ISO-1CC төрлийн битүүмжлэлтэй контейнер-цистернээр төмөр замаар нийлүүлнэ. Хүхрийн хүчлийн агуулахыг ТТ-Зүүнбаян төмөр замын 5-р зөрлөг дээр байгуулах ба байгууламжийн суурийг цутгамал төмөр бетон нил сууриар төлөвлөсөн. Үйлдвэрийн талбайд хүхрийн хүчлийг тус бүр нь 5.3 м-ийн диаметртэй, 5.3 м өндөртэй, 112 $м^3$ ашигт эзлэхүүнтэй 3ш ган танкад хадгалахаар тооцсон бөгөөд нийт эзлэхүүн 337$м^3$ байна.

**Дулаан хангамж -** Дулаан хангамжийн хэрэглээг уурын зуухаар хангах бөгөөд жилд ойролцоогоор 25.5мян.тн нүүрс хэрэглэхээр байна.

**Цахилгаан хангамж -** “Цагаан суваргын Катодын-Зэсийн Үйлдвэр” нь Цагаан суварга орд, MV-009630 Сэрвэнсухайт талбайн ил уурхайн зүүн хойно байгуулагдах тул үйлдвэрийн цахилгаан хэрэглээг одоо ашиглагдаж буй Цагаансуваргын ил уурхайн цахилгаан хангамжаас хангах бөгөөд үйлдвэр хүртэлх цахилгааны шугамын өргөтгөл, шинэчлэлийг хийнэ.

# БҮЛЭГ 2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“МАК Аранжин Зэс” ХХК-ийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэрийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсын байгаль орчны багц хууль, дүрэм журам, стандартуудыг шаардлагыг биелүүлж, төслөөс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллүүдийг арилгах, бууруулах зорилгоор энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэв.

## 2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэрийн 2025 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба 2025 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд **41,391,559** төгрөг зарцуулав.

*Хүснэгт 2-1. БОМТ-ний зардлын хураангуй*

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | | Нийт зардал, төг |
|---|---|---|---|
| 1 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | *11,693,559* |
| 2 | | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | *5,000,000* |
| | | Ногоон байгууламжийн төлөвлөгөө | *1,650,000* |
| 3 | | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | *2,000,000* |
| 4 | | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 5 | | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | *3,000,000* |
| 7 | | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | *6,850,000* |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | | *5,198,000* |
| *9* | Удирдлага зохион байгуулалт | | *6,000,000* |
| ***Нийт зардал*** | | | ***41,391,559*** |

2025 онд Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн хүрээнд гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр буюу агаарын чанар, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, усан орчинд, биологийн олон янз байдалд тодорхойлж, 47 сөрөг нөлөөлөл түүнийг бууруулах 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

## 2.2 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэрийн хүрээнд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 8 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлсэн.

*Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Барилгын ажлын газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх | Барилгын ажлын үед тоосжилт үүсэх газар шорооны ажлын үед усалгаа хийх | Үйл ажиллагааны зардал | | | Усны машинаар дулааны улиралд долоо хоног бүр зам талбайн усалгааг хийж гүйцэтгэсэн. /Дэлгэрэнгүйг 2.2.1-үзнэ үү/ |
| 2 | Исэлдсэн хүдэр болон дайрга тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх | Улаан шаврын тээвэрлэлтийг түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх | Үйл ажиллагааны зардал | | | Улаан шавар олборлолт хийх ажил хөрс хуулалтын ажил хойшилсон. |
| 3 | | Үйлдвэрийн дотоод шороон замыг тогтмол засаж сайжруулах, нягтаршуулах | Үйл ажиллагааны зардал | | | Түр шороон зам ашиглаж арчилгаа усалгааны ажлыг хийж байна. /Дэлгэрэнгүйг 2.2.1-аас үзнэ үү/ |
| 4 | | Үйлдвэрийн түр шороон зам дагуу MNS 4597:2014 стандартын дагуу замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах | 100,000 | 10 | 1,000,000 | |
| 5 | | Үйлдвэрийн замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зохицуулалт хийх (Үйлдвэрийн дотоод зам дээр ачаатай тээвэрлэлт хийхдээ | Үйл ажиллагааны зардал | | | Үйлдвэрийн замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зохицуулалт хийж хурдны хязгаар, |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|
| | | хурдны хязгаарыг 20 км/цагт тогтмол барих ба ачаагүй үед хурдны хязгаарыг 30 км/цагт барих) | | | | зогсоолын тэмдэг байршуулан хяналт тавьж ажилласан. /Дэлгэрэнгүйг 2.2.2-аас үзнэ үү/ |
| 6 | | Исэлдсэн хүдрийн овоолго, түр зам, Оффис, УХЗ зэрэг газруудад агаарын тоосжилтын хэмжилт тогтсон хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг хянаж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тоос бууруулах арга хэмжээг авах | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | | | ОХШХ хүрээнд Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори агаарын чанарын хэмжилт хийлгэсэн. /Дэлгэрэнгүйг 2.2.1-аас үзнэ үү/ |
| 7 | Исэлдсэн хүдрийн овоолго, ачиж буулгах, хөрсний овоолго гэх мэт үйл ажиллагаанд нийт 13 хүнд даацын машин, тээврийн хэрэгсэл ашиглагдаж, эдгээр тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах | Тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийх, ашиглалтын хугацаа дууссан, утаа ихээр ялгаруулдаг машин техникийг үйл ажиллагаанд ашиглахгүй байх | Үйл ажиллагааны зардалд тусгаснаар | | | Бүх төрлийн тээврийн хэрэгсэл болон хөдөлгүүрт төхөөрөмжүүдийг засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэдэг бөгөөд Хөнгөн тэрэгний ангилалд хамаарагдах тээврийн хэрэгслүүдэд 5000км, 8000км, 20000км тутамд тос солих болон бусад шаардлагатай үйлчилгээнүүдийг хийдэг бол дунд оврын тээврийн хэрэгслүүдэд 250, 500, 1000, 2000, 4000 мот/цаг тутамд, хүнд даацын тээврийн хэрэгслүүдэд 50, 500, 1000, 2000, 4000, 8000 мот/цаг тутамд тос солих болон бусад шаардлагатай үйлчилгээнүүдийг хийдэг. Үүн дээр нэмэх нь дотоод улирлын болон улсын жил тутмын үзлэг зэргийг тогтмол хийж гүйцэтгэж байна. |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Дизель генераторын түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах | Дизель генератораас ялгарах хорт хийг шүүх шүүлтүүр суурилуулах, шүүлтүүрийг заасан хугацаанд тогтмол солих | Үйл ажиллагааны зардалд тусгаснаар | | | Дизель генератораас ялгарах хорт хийг шүүх шүүлтүүр суурилуулах, шүүлтүүрийг тухай бүр солилуулав. /Дэлгэрэнгүй |
| **Нийт зардал, төг** | | | **1,000,000** | | | |

### 2.2.1 Зам талбайн тоосжилтыг бууруулах үйл ажиллагаа

Барилгажилтын үед түр шороон зам ашиглаж байгаа бөгөөд байнгын усалгаа хийж дагтаршуулах арга хэмжээг авч байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа нийт тоос, тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг. Төслийн талбайд замын тоосжилтыг бууруулах зорилгоор түр шороон замуудад 40 тонны усны белазаар 7 хоногт 1-2 удаагийн давтамжтайгаар усалгаа хийгдэж байна.







*Зураг 2-1. “МАЗ” уурхайн зам усалгаа*

### 2.2.2 Үйлдвэрийн дотоод шороон зам засвар

Авто замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний горим, нөхцөл байдлыг хөдөлгөөнд оролцогчдод мэдээлэхэд зориулсан MNS 4597:2014 стандартыг хангасан тэмдэг тэмдэглэгээг уурхайн дотоод зам дагуу байршуулсан бөгөөд анхааруулах тэмдэг, хориглох тэмдэг, дараалын тэмдэг, заах тэмдэг, мэдээлэх тэмдэг, нэмэлт зэрэг нийт 42 тэмдгийг уурхайн шороон дотоод замын дагуу байршуулсан.




*Зураг 2-2. Төслийн талбай дах авто замын тэмдэг тэмдэглэгээний байршил*




*Зураг 2-3. Хурдны хязгаар, зогсоолын тэмдэг*

### 2.2.3 Агаарын чанарын хэмжилт

Төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг сөрөг нөлөөлөл үүсгэж болохуйц ажлын талбаруудаас хамаарч агаарын чанарын нийт 6 цэгт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар дах тоос тоосонцор (TSP, PM10, PM2.5), хүхэрлэг хий (SO2), азотын давхар ислийн (NO2) агууламжийг жилийн турш төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.



*Зураг 2-4. Агаарын чанарын хэмжилт*

## 2.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

2025 онд Цагаан суваргын Катодын зэсийн үйлдвэр төслийн хүрээнд усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 10 арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Галба-Өөш долоодын говийн сав газрын мэргэжилтнүүд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.15 дахь заалтыг тайлбарлаж, аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр илрүүлсэн усны нөөц нь төслийн хэрэгцээг бүрэн хангаж илүү гарсан тохиолдолд усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн бусад аж ахуйн нэгжид ашиглуулах боломжтойг мэдээлэв. Цагаан суваргын үндсэн төслийн объектуудад ажиллаж, усан хангамжийн эх үүсвэрээс ашиглаж байна.

*Хүснэгт 2-3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 1 | Төслийн үйл ажиллагаанд гүний ус ашиглах, усыг зөв зохистой ашиглаагүй тохиолдолд усны нөөцөд сөргөөр нөлөөлөх | Усны тухай хуулийн дагуу ус ашиглуулах зөвшөөрөл, дүгнэлтийг гаргуулж, сав газартай ус ашиглах гэрээ байгуулсны үндсэн дээр усыг ашиглах | Үйл ажиллагааны зардал | Цагаан суваргын үндсэн төслийн хүрээнд Усны газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Е-2504-000218 дугаар ус ашиглуулах дүгнэлтэд үндэслэн Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаанаас А/20 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг авч ус ашиглах гэрээ байгуулан ашигладаг. Сав газрын мэргэжилтнүүд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.15 дахь заалтыг тайлбарлаж, аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр илрүүлсэн усны нөөц нь төслийн хэрэгцээг бүрэн хангаж илүү гарсан тохиолдолд усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн бусад аж ахуйн нэгжид ашиглуулах боломжтойг мэдээлэв. Мөн усны эрэл хайгуулын нийт зардлаас тухайн аж ахуйн нэгжид нийлүүлэх усны хайгуулын ажилд зарцуулсан зардлыг нөхөн төлүүлэх боломжтой талаар зөвлөмж өгсний дагуу боломжит усны нөөцийн дүгнэлт гаргуулж байна. |
| 2 | | Төслийн усны хэрэглээг сар бүр дотоод системд бүртгэх хянах | Үйл ажиллагааны зардал | Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй усны хэрэглээг дотоод систем буюу ERP-д бүртгэн хяналт тавьж ажилладаг. /Дэлгэрэнгүйг 2.3.1-ээс үзнэ үү/ |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 3 | | Усан хангамжийн худгуудын тоолуурыг баталгаажуулалтыг сар бүр сумын байгаль орчны байцаагчаар хийлгэх, тоолуурын заалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх. | 1,340,969 | Усан хангамжийн худгуудын тоолуурын баталгаажуулалтыг сар бүр сумын байгаль орчны байцаагчаар баталгаажуулан, тоолуурын заалтад үндэслэн байгалийн нөөц ус ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна. /Дэлгэрэнгүйг 2.3.2-с үзнэ үү/ |
| 4 | | Төслийн үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн журмын хэрэгжилтийг дагаж мөрдөн ажиллах | Үйл ажиллагааны зардал | “Монголын алт” ХХК-ийн ерөнхийлөгчийн 2022 оны 12-р сарын 02-ны өдрийн А/1223-р тушаалаар батлагдсан Усны менежментийн журмыг уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд дагаж мөрдөн ажиллаж байна. Уг журмаар төслийн үйл ажиллагааны үед усны нөөцийг эрэх, хайх, ашиглахтай холбоотой хуулийн нийцлийг хангах, усны нөөцийг үр ашигтай зарцуулах, хэмнэх нөөц бололцоог нэмэгдүүлэх, усны нөөцийн хэмжээ ба чанарт хяналт, мониторинг хийх зорилгоор дагаж мөрддөг /Дэлгэрэнгүйг 2.3.3-с үзнэ үү/ |
| 5 | | Ус дамжуулах шугам хоолойн ашиглалтад тогтмол хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд | Үйл ажиллагааны зардал | Ус дамжуулах хоолойн ашиглалтад тогтмол хяналт тавьж гэмтсэн тохиолдолд тухай бүр засах арга хэмжээ авч ажилласан. Гүний ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулан ашиглаж байна. /Дэлгэрэнгүйг 2.3.4-с үзнэ үү/ |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| | | тухай бүр засах арга хэмжээ авах. | | |
| 6 | | Дэлхийн усны өдрийг угтан ажилчдад усыг ариг гамтай ашиглах, усны хэрэглээг бууруулах тухай сургалт зохион байгуулах, усны өдрийг тэмдэглэн өнгөрөөх. | 1,000,000 | Дэлхийн усны өдрийг тохиолдуулан дэлхий нийтийн өмнө тулгамдаа буй цэвэр усны нөөцийн асуудлын талаар мэдээллийг багтаасан хананы самбарыг бэлтгэн нийт ажилчдад мэдлэг мэдээлэл түгээсэн. /Дэлгэрэнгүйг 2.3.6-с үзнэ үү/ |
| 7 | | Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт шинэчилж тавих | Үйл ажиллагааны зардал | Ус ашиглаж байгаа цэгүүдэд усыг арга гам ашиглах, усны цоргоор ус дусахыг хязгаардах үүднээс мэдээллийн хуудсыг байршуулан ажиллаж байна. /Дэлгэрэнгүйг 2.3.7-с үзнэ үү/ |
| 8 | Төслийн үйл ажиллагаа, ажилчдын санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас | ОХШХ-ын дагуу гүний усны бохирдлын мониторингийг тогтмол хийж, стандарт | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгах | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу гүний ус болон гадаргын усны мониторингийн ажлыг зохион байгуулж ажилласан. Усны химийн шинжилгээг тогтмол хийлгэдэг. /Дэлгэрэнгүйг 2.3.8-с үзнэ үү/ |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| | орчны бохирдол үүсэх, газрын доорх усны чанарт нөлөөлөх | шаардлагаас давсан тохиолдолд тухай бүр арга хэмжээ авах. | | |
| 9 | Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд хөрсний бохирдол үүсэх, усны найрлага шинж чанарт сөргөөр нөлөөлөх | Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих, шинжилгээ хийлгэх | 2,852,590 | Ахуйн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн болгох үүднээс төслийн талбайд ашиглагдаж буй цэвэрлэх байгууламжуудыг засварлахаар ажиллаж байна. Хаягдал усны дээжийг улирал бүр авч шинжлүүлсэн. Шинээр баригдаж буй ахуй бохир ус цэвэршүүлэх байгууламжийн барилгын ажил 70 хувьтай байна. /Дэлгэрэнгүйг 2.3.9-с үзнэ үү/ |
| 10 | | Хаягдал усны дүгнэлтийг гаргуулж, ус бохирдуулсны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх. | *I улиралд* | 2025 оны хаягдал усны дүгнэлтийг улирал бүрээр гаргуулахаар хүсэлтийг ewater.mn оруулсан. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаатай байгуулж, хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг авсан. /Дэлгэрэнгүйг 2.3.10-с үзнэ үү/ |
| | ***Нийт зардал*** | | **5,193,559** | |

Ус ашиглах гэрээ дүгнэлт

Монгол улсын "Усны тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу 2024 оны 05-р сарын 28-ны өдөр 01 тоот ус ашиглуулах дүгнэлтийг Галба-Өөш-Долоодын Говийн сав газрын захиргаагаар гаргуулсан.

"Усны тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7 дахь заалт, 2 9 дүгээр зүйлийн 29.1-т заасны дагуу Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2025 оны 05-р сарын 26-ны өдрийн А/20 тоот тушаалыг үндэслэн 2025 оны 06-р сарын 17-ны өдөр 25/10 тоот ус ашиглах гэрээг байгуулсан.

*Хүснэгт 2-4. Ус ашиглах гэрээ*

| ***Гэрээний дугаар*** | **Эхлэх** | **Дуусах** | **Ус ашиглах зориулалт** | **Ашиглах усны хэмжээ** |
|---|---|---|---|---|
| *084-5125* | 2025.06.17 | 2025.12.31 | Эрчим хүчний үйлдвэрлэлд | 94,802.96 $м^3$/жил |
| | | | Барилга барилгын материал үйлдвэрлэхэд | 3,900 $м^3$/жил |
| | | | Шүүрлийн усны хэмжээ | 31,248 $м^3$/жил |
| | | | Унд ахуйн усны хэмжээ | 4,005 $м^3$/жил |

Төслийн хүрээнд 2025 оны 1-р сараас 10-р сар хүртэл тоолуурын заалтаар нийт **17743** $м^3$ ус ашигласан байна.


БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

2025.10.15 № 3/46

"ЭРДЭНЭС ЦАГААН СУВАРГА" ХХК-Д

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Сав газрын захиргааны даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн ус ашиглалтын байдалд хяналт, шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт, ус ашиглалтын байдалд хийсэн шалгалтаар танай компани нь 2025 оны 1,2,3 дугаар улирлын хаягдал усны дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулаагүй, ус бохирдуулсны төлбөр төлөөгүй. /2025 оны хаягдал усны дүгнэлтийг улирал бүр гарган ажиллах Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт/

Мөн 2025 оны ус ашиглах дүгнэлтэд зам талбайн усалгаанд шүүрлийн ус ашиглана гэж заасан боловч шүүрлийн ус гараагүй. Зам талбайн усалгаанд гадаргын ус ашигласан тул усны машины усалгаа хийсэн бүртгэлийн дагуу усны төлбөрийг төлж барагдуулах.

Дээрх зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг яаралтай зохион байгуулж ажил гүйцэтгэсэн тайлан мэдээг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Тогтоосон хугацаанд тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авахыг анхааруулъя.

Цаашид дараах зүйлсийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг анхааруулъя.

1.2025 оны ус ашиглах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж 12 дугаар сарын 30-ны дотор гэрээний хэрэгжилт, тухайн оны ус ашиглалтын тайланг ирүүлэн 2026 оны 1 дүгээр сард багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнүүлэх;

2.2026 оны ус ашиглуулах дүгнэлтийг 3 дугаар сарын 1-ний дотор гаргуулж ус ашиглах гэрээ байгуулах;

3.Ундаанд хэрэглэж байгаа усанд хийлгэсэн шинжилгээний хариугаар усанд байх ёстой эрдсүүд 0% байна. Иймд ундаанд хэрэглэж байгаа усыг MNS0900:2018 стандартад нийцүүлэх;

4.Нарангийн хоолойн газрын доорх усны ордод компанийн өөрийн 3-аас доошгүй мониторингийн цооног гарган тоноглож Монгол Улсын газрын доорх усны мониторингийн сүлжээнд холбох;

ДАРГА Б.ЯЛАЛТБАЯР

*Зураг 2-5. Галба өөш долоодын говийн сав газрын захиргаанаас ирсэн хяналт шалгалт*

### 2.3.1 Ус ашиглалтын мэдээг дотоод системд бүртгэх

Ус ашиглалтын хэмжээг сар бүр дотоод систем ERP-д оруулан бүртгэл мэдээллийг хөтөлсөн.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2025 (8) | | | | | 10,811.00 | 13,793.00 | | |
| 1 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-07-31 | Ус ашиглалт | 2,953.00 | 2,953.00 | НОМИНЗАЯА.Б [ЭЦС] | Ноорог |
| 2 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-08-28 | Ус ашиглалт | 2,314.00 | 2,314.00 | НОМИНЗАЯА.Б [ЭЦС] | Ноорог |
| 3 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-03-31 | Ус ашиглалт | 933.00 | 933.00 | НОМИНЗАЯА.Б [ЭЦС] | Ноорог |
| 4 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-02-28 | Ус ашиглалт | 784.00 | 784.00 | ГУНДЭГМАА.Б [БОТХГ] | Ноорог |
| 5 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-04-22 | Ус ашиглалт | 763.00 | 763.00 | НОМИНЗАЯА.Б [ЭЦС] | Ноорог |
| 6 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-01-31 | Ус ашиглалт | 0.00 | 982.00 | ГУНДЭГМАА.Б [БОТХГ] | Батлагдсан |
| 7 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-05-31 | Ус ашиглалт | 258.00 | 2,258.00 | НОМИНЗАЯА.Б [ЭЦС] | Ноорог |
| 8 | | Эрдэнэс Цагаан Суварга | 2025-06-30 | Ус ашиглалт | 2,806.00 | 2,806.00 | НОМИНЗАЯА.Б [ЭЦС] | Ноорог |

*Зураг 2-6. Ус ашиглалтын мэдээг ERP системд хөтөлсөн байдал*

*Хүснэгт 2-5. Шүүрлийн ус ашиглалтын мэдээлэл*

| ***Ус ашиглах зориулалт*** | **Ашигласан усны хэмжээ м$^3$** |
|---|---|
| *Бетон зуурмаг үйлдвэрлэх* | 2640 |
| *Ногоон байгууламж* | 3720 |
| *Зам талбайн тоосжилт дарах* | 11,760 |
| *Нийт* | 18,120 |

### 2.3.2 Усны тоолуурын баталгаажуулалт, ус ашигласны төлбөр

2024 оны 03-р сарын 21-ний өдөр төслийн усан хангамжийн 2 худагт Мандах сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнийг байлцуулан тоолуур суурилуулах акт үйлдүүлсэн.

*Хүснэгт 2-6. Усан хангамжийн худгууд*

| **№** | **Худгуудын дугаар** | **Байршил** | |
|---|---|---|---|
| | | **Өргөрөг** | **Уртраг** |
| *1* | ЭЦ-09-21 | 44$^0$00’05.9” | 108$^0$26’03.6” |
| *2* | ЭЦ-09-16 | 44$^0$00’19.1” | 108$^0$26’44.6” |







*Зураг 2-7. Усны тоолуур суурилалт*

Түүнчлэн усан хангамжийн худгуудын усны тоолууруудыг 2025 оны 04-р сарын 24-ны өдрөөс 2027 оны 04-р сарын 24-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатайгаар Стандарт хэмжил зүйн газраар албан ёсоор баталгаажуулсан.


СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ ......244836

Эрдэнэс цагаан суварга .....-д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXLC - 80 загварын 40 м³/ц

хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 20230414З -ын

халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2027 оны 04 -р сарын 24 -ны өдөр хүртэл улсын

баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 000056 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2025 оны 04 -р сарын 24 -ны өдөр

*Зураг 2-8. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ*

Ус ашигласны төлбөрийн хэмжээг усны эх үүсвэр дээр (худагт) байрлуулсан усны тоолуурын заалтын зөрүүг үндэслэн баталгаажуулж Мандах сумын байгаль орчны байцаагчаар 2025 оны 10-р сарын 15-ны өдөр хянуулсан.

2025 оны 10-р сарын байдлаар төслийн хэмжээнд ус ашигласны төлбөрт нийт **1,340,969** төгрөгийг төлөөд байна.


ГОЛОМТ БАНК — Сайн сайхны санхүүжүүлэгч

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 362423343 Татсан огноо: 2025-09-03 17:13

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 8140000215 MN750015008140000215 | 1165117377 | 564,659.20 MNT | Амжилттай |
| Шилжүүлэгчийн нэр: ЭРДЭНЭС ЦАГААНСУВАРГА ХХК | Хүлээн авагчийн нэр: ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР | Гүйлгээний утга: 3250602335752;64101408182;5824826;64101408182;98020208 | |
| | Хүлээн авагчийн банк | Гүйлгээний огноо: 2025-09-03 | |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| С. Азхүү | Д. Ариунбаатар | Г. ЦОГТ |

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

ГОЛОМТ БАНК — Сайн сайхны санхүүжүүлэгч

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 349101593 Татсан огноо: 2025-06-27 08:27

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 8140000215 MN750015008140000215 | 1165117377 | 776,310.50 MNT | Амжилттай |
| Шилжүүлэгчийн нэр: ЭРДЭНЭС ЦАГААНСУВАРГА ХХК | Хүлээн авагчийн нэр: ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР | Гүйлгээний утга: 3250602335752;64101408182;5824826;64101408182;98020208 | |
| | Хүлээн авагчийн банк | Гүйлгээний огноо: 2025-06-26 | |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| С. Азхүү | Д. Ариунбаатар | Г. ЦОГТ |

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

*Зураг 2-9. Усны төлбөр төлсөн баримт*

### 2.3.3 Усны менежментийн журмын хэрэгжилт

“Монголын алт” ХХК-ийн ерөнхийлөгчийн 2022 оны 12-р сарын 02-ны өдрийн А/1223-р тушаалаар батлагдсан Усны менежментийн журмыг уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд дагаж мөрдөн ажиллаж байна. Уг журам нь нийт 9 бүлэг 35 дэд хэсэгтэй бөгөөд дараах зорилттой. Үүнд:

1. Усны нөөцийг эрэн хайх, ашиглахтай холбоотой хуулийн нийцлийг хангах
2. Усны нөөцийг үр ашигтай зарцуулах, хэмнэх нөөц бололцоог нэмэгдүүлэх
3. Усны нөөцийн хэмжээ ба чанарт хяналт, мониторинг хийх

Түүнчлэн журмын хүрээнд нэгжийн эрх үүргийг нэг бүрчлэн тусгасан байдаг бөгөөд 2025 онд журмын хэрэгжилтийг ханган уурхайн нийт ажилчид, төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт компаниудад шаардлага тавин ажилласан.



МАК
"МОНГОЛЫН АЛТ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

20..22 оны ..12 дугаар сарын ..02-ны өдөр | Дугаар А/1223 | Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Компани болон түүний охин, хараат, хамаарал бүхий компаниудын байгалийн усны нөөцийг эрэх, хайх, ашиглахтай холбоотой харилцаа, байгаль орчинд үзүүлж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах менежментийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор “Усны менежментийн журам”-ыг энэ тушаалын ***Хавсралт №1***-ээр баталж, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Журмыг мөрдөж ажиллахыг нийт нэгжийн удирдлагууд болон ажилтнуудад, журмыг сурталчлан таниулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны алба /Д.Сарантуяа/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар /Г.Ганчулуун/-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦЭЛМҮҮН



“Монголын Алт” (МАК) ХХК | Албан хэрэгцээнд

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2022 оны ...12... дугаар сарын ...02... -ны өдрийн А/1223 тоот тушаалын, Хавсралт№......1...., Хуудас№..1..

**УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЖУРАМ**

***1. Зорилго***

“Монголын Алт” (МАК) ХХК /цаашид “Компани” гэх/ болон түүний охин, хараат, хамаарал бүхий этгээдүүдийн байгалийн усны нөөцийг эрэх, хайх, ашиглахтай холбоотой үүсэх хуулийн харилцаа болон байгаль орчинд үзүүлж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах менежментийн нэгдсэн тогтолцоог бий болгоход оршино.

***2. Зорилт***

Усны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:
- Усны нөөцийг эрэх хайх, ашиглахтай холбоотой хуулийн нийцлийг хангах
- Усны нөөцийг үр ашигтай зарцуулах, хэмнэх нөөц боломжоор нэмэгдүүлэх
- Усны нөөцийн хэмжээ ба чанарт хяналт, мониторинг хийх

***3. Хамрах хүрээ***

3.1 Энэхүү журмыг Компанийн хэмжээнд дагаж мөрдөнө.
3.2 “Нэгж” гэдэгт нутаг дэвсгэрт байрлах газарт хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа Компанийн нэгж /үйлдвэр, уурхай, төсөл хариуцсан нэгж/ болон Геологи, хайгуулын асуудал хариуцсан нэгж, Санхүү бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, Аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан нэгж, Бизнес хөгжлийн асуудал хариуцсан нэгж, Үйлдвэр техникийн асуудал хариуцсан нэгжийг тус тус ойлгоно.
3.3 Нэгжүүд энэхүү журмыг үйл ажиллагааны бүх үе шатанд дагаж мөрдөнө. Үүнд:
- Ашигт малтмалын хайгуулын үе шат
- Барилга, бүтээн байгуулалтын үе шат
- Олборлолт, боловсруулалт, баяжуулалт, барилгын материалын үйлдвэрлэлийн үе шат
- Үйлдвэр, уурхайн хаалтын дараа тодорхой заасан хугацаанд

3.4 Усны менежментийн журам нь Бүлэг 5. Усны менежментийн үйл ажиллагаанд тусгасан “Үйл явцын зураглалууд”-ын хүрээнд хэрэгжинэ. Хуулийн өөрчлөлт, компанийн усны бодлого, үйл ажиллагаанд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөгдөх, шинэчлэгдэх боломжтой.

- Компанийн усны менежментийн журам

1

*Зураг 2-10. Усны менежментийн журам*




*Зураг 2-11. Нийт ажилчдын эрх, үүрэг*

### 2.3.4 Ус дамжуулах хоолой засвар

Ус дамжуулах хоолойн ашиглалтад тогтмол хяналт тавьж гэмтсэн тохиолдолд тухай бүр засах арга хэмжээ авч ажилласан. Гүний ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж шинээр суурилуулан ашиглаж байна. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн гадна шугам хоолойн ажил 81.4 хувьтай явагдаж байна.



*Зураг 2-12. Ус дамжуулах хоолой угсрах ажил*

Унд ахуйн ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмжийг “Сөүт партс” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн.



*Зураг 2-13. Ус цэвэршүүлэн эрдэсжүүлэх төхөөрөмж*

### 2.3.5 Гадаргын ус цуглуулах цөөрөм

| 4 | Үер усны аюул | Далан, шуудуу татах, техникийн бэлэн байдлыг хангах | Хөрөнгө оруулалтын зардал | Катодын Зэсийн үйлдвэрийн нуруулдан уусгах байгууламжийн үерийн далангийн ажил хийгдсэн. (Дэлгэрэнгүйг 8.1.4-с үзнэ үү.) |

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 5 | Цахилгаан тоног төхөөрөмж болон цахилгаан гүйдэлд нэрвэгдэх | Анхан шатны тусламж үйлчилгээний сургалт зохион байгуулах | 2,000,000 | 2025 оны 6 сард Эрдэнэс Цагаан Суварга Уурхайн эмч анхан шатны тусламж үйлчилгээний сургалт зохион байгуулсан. . (Дэлгэрэнгүйг 8.1.5-с үзнэ үү.) |
| 6 | Гал гарах аянга буух | Газардуулгын хэмжилт хийлгэх | 1,000,000 | Үйлдвэрийн барилга угсралтын үйл явц дуусаагүй байгаа тул, Газардуулгын хэмжилт хийлгэх ажил 2026 онд хийгдэхээр төлөвлөж байна. . (Дэлгэрэнгүйг 8.1.6-с үзнэ үү.) |
| 7 | Аюулгүй ажиллагааны зааварчилгаа ноцтой зөрчигдөх | Аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагааны зардал | Нийт ажиллагсдын ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулж танилцуулсан. Мөн ажилчид танилцсан хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулсан.<br>(Дэлгэрэнгүйг 8.1.7-с үзнэ үү.) |
| 8 | Байгалийн давагдашгүй хүчин зүйл | Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах | | Үйлдвэрийн барилга угсралтын үйл явц дуусаагүй байгаа тул, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2026 онд боловсруулна. |
| | **Нийт зардал** | | **3,000,000** | |

### 8.1.1 Гал түймэртэй тэмцэх бүтэц орон тоог батлуулж ажиллуулах, Техник, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх.

“Эрдэнэс Цагаан Суварга” уурхай 2025 онд бүтэц, орон тоогоор Онцгой байдлын мэргэжилтэн-2, гал унтраах автомашины жолооч 2 тус тус байхаар төлөвлөсөн бөгөөд Онцгой байдлын мэргэжилтэн 1 нэмж авах сонгон шалгаруулалт хийгдсэн. “Эрдэнэс Цагаан Суварга” ХХК-н онцгой байдлын алба нь, “МАК Аранжин Зэс” Катодын зэсийн үйлдвэрийн гал түймэртэй тэмцэх албыг давхар хариуцан ажилладаг.

### 8.1.2 Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлэх

Талбайн түр оффисын хэсэгт галын булан болон галын хөнжил, гал унтраагуур, бөмбөлөгөн задардаг унтраагуур, элс гэх мэт зүйлсийг байршуулсан.




*Зураг 8-1. Түр оффис галын булан*

### 8.1.3 Галын аюулын талаар анхааруулга самбар, ааварын гарц, барилгын зохион байгуулалт

Катодын зэсийн үйлдвэрийн барилга угсралтын үйл явц үргэлжилж байна. Иймээс объект баригдаж дуусах үед, галын аюулын талаар анхааруулга самбар, ааварын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн барилга байгууламж бүрд онцлогийг тусган шинэчлэн тавих, объектод анхааруулах самбар, гарц чиг заасан тэмдгийг байршуулах. Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсдад сургалт зохион байгуулах төлөвлөгөөт ажил зохион байгуулна.



*Зураг 8-2. Төслийн барилга, угсралтын ажлын явц*

### 8.1.4 Далан, шуудуу татах техникийн бэлэн байдлыг хангах

Үер усны аюулаас сэргийлэх далангийн ажил гүйцэтгэл үргэлжилж байна. Катодын Зэсийн үйлдвэрийн нуруулдан уусгах байгууламжийн үерийн далангийн ажил 70% тай хийгдэж байна.



*Зураг 8-3. Үерийн далангийн урд хэсэг*

### 8.1.5 Анхан шатны тусламж үйлчилгээний сургалт зохион байгуулах

Эрдэнэс Цагаан Суварга уухайн талбарын эмч, сувилагч дотоодын ажилчдад анхны тусламж хэрхэн үзүүлэх, яаралтай үед ямар арга хэмжээ үзүүлэх тухай сургалт зохион байгуулсан.



*Зураг 8-4. Анхны тусламжийн сургалт*

### 8.1.6 Газардуулгын хэмжилт хийлгэх

Катодын зэсийн үйлдвэрийн барилга угсралтын үйл явц үргэлжилж байна. Иймээс объект баригдаж дуусах үед, үйлдвэр оффисын нийт байгууламжид, мэргэжлийн байгууллагаар газардуулгын хэмжилт хийлгэх ажлыг зохион байгуулна.



*Зураг 8-5 Үйлдвэрийн барилга угсралтын үйл явц*

### 8.1.7 Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулж Компани нийт ажилчдад танилцуулах ажил зохион байгуулсан. ХАБЭА-н тухайн хуульд заасны дагуу 3 хэлбэрээр зааварчилгааг өгөх тогтолцоог нэвтрүүлж тухайн хэлтэс нэгжийн шууд удирдлага өөрийн харьяалагдах албаны хүмүүстээ өглөө бүр зааварчилгаа өгч ХАБ-н ажилтан хяналт тавьж дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



*Зураг 8-6 ХАБЭА-н зааварчилгааны бүртгэл*

### 8.1.8 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах

Гамшгаас хамгаалах хуулийг хэрэгжүүлэх, тухайн объектод учирч болох гамшгийн эрсдэлийг үнэлэх болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний үндсийг бүрдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах тухай хуулийн 7-р зүйл, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17-р зүйлийг үндэслэн “МАК Аранжин Зэс” ХХК болон “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төвийн” хамтран ажиллах ажлыг үйлдвэр барилга угсралтын төсөл гүйцэтгэж дууссаны дараа зохион байгуулна.

# БҮЛЭГ 9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа эхлэхгүй хайрга бэлтгэл, шүүрлийн хоолой байрлуулах, геомембран дэвсэх зэрэг барилгын үйл ажиллагаа явагдах бөгөөд төслийн талбай нь үндсэн уурхайн талбай дотор байрлахаас гадна барилгын ажилчид Цагаан суваргын үндсэн төслийн объектуудад ажиллах тул хог хаягдлын менежменттэй холбоотой бүхий л үйл ажиллагаа Эрдэнэс Цагаан Суварга ХХК-ийн хог хаягдлын тээвэрлэлт, хадгалалт, устгалын төлөвлөлттэй хамтдаа зохицуулагдахаар байна.

МАК Аранжин Зэс ХХК нь “Монголын Алт” ХХК-ийн ерөнхийлөгчийн 2021 оны 06-р сарын 23-ны өдрийн А/383 тоот тушаалаар батлагдсан “Хог хаягдлын менежментийн журам”-ыг уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд мөрдөн ажилладаг. Тус журмын зорилт нь:

- Хог хаягдлын тухай хууль, журам, стандартыг дагаж мөрдөх
- Хог хаягдлын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэхэд оролцох ажиллагсад, албан тушаалтны оролцоо, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох
- Хог хаягдлын менежментийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг хянах, үнэлгээ хийх, сайжруулалт хийх
- Хог хаягдлын статистик тоон баримт, хяналт мониторингийн үр дүнг эмх цэгцтэй нэгтгэн хадгалах, урт хугацааны мэдээллийн санг үүсгэх, шаардлагатай газруудад танилцуулах, мэдээлэх
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах боломж бололцоог нэмэгдүүлэх.

Журмын дагуу хог хаягдлыг үндсэн хоёр төрөлд буюу энгийн болон аюултай хог хаягдал гэж ангилдаг. Энгийн хог хаягдлыг дахин ашиглах боломжтой хог хаягдал болон дахин ашиглах боломжгүй хог хаягдал гэсэн 2 үндсэн төрлөөр ангилж байна. Харин аюултай хог хаягдлыг дахин ашиглах боломжтой аюултай хог хаягдал, дахин боловсруулах боломжтой аюултай хог хаягдал, дахин боловсруулах боломжгүй аюултай хог хаягдал болон тусгай буюу эмнэлгийн хог хаягдал гэсэн 4 үндсэн төрлөөр ангилж байна.



*Хүснэгт 9-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

| № | *Хог хаягдлын ангилал* | *Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ* | *Нийт зардал, төг* | *Хэрэгжилт* |
|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хог хаягдал | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг төслийн талбайд байршуулах | 850,000 | Төслийн талбайн хэмжээнд энгийн хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд буюу ажилчдын кемп, оффис, гал тогоо гэх мэт 6 газарт ангилан ялгалттай хогийн савыг стандарт шаардлагын дагуу байрлуулсан. |
| 2 | | Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны зардал | Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусгаарлаж хадгалж байна. /хуванцар, сав/ |
| 3 | | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах цэгийн зураг төслийг гаргаж, төлөвлөх, ангилан ялгалттай цэгийг байгуулах | Хөрөнгө оруулалтын зардал | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах цэгийн зураг төслийг боловсруулж төлөвлөгөө гаргасан. |
| 4 | | Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах төсөл, хөтөлбөрт эсвэл гэрээт компанид нийлүүлэх | Үйл ажиллагааны зардал | Дахин ашиглах боловсруулах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах эрх бүхий “Төвшин сайхан” төвтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. |
| 5 | | Хүнсний үлдэгдлээр бордоо хийж турших | 1,000,000 | Хоол үйлдвэрлэлийн газраас гарч буй хүнсний хаягдлаар бордоо бэлтгэхээр турших байна. |
| 6 | | Бусад хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр устгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 5,000,000 | Бусад хог хаягдлыг төвлөрсөн цэгт хуримтлуулан Мандах сумын энгийн хог хаягдлын цэгт хүлээлгэж өгсөн. |
| 7 | | Төслийн талбайн эргэн тойронд нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах | Үйл ажиллагааны зардал | Төслийн талбай болон түүний ойр орчимд улирал бүр хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээг зохион байгуулж байна. |
| 8 | Аюултай хог хаягдал | Засвар үйлчилгээний төвөөс үүсэх аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хийсэн гэрээний дагуу төслийн талбайгаас тээвэрлүүлж, устгуулах | Үйл ажиллагааны зардал | “МАК Аранжин Зэс” ХХК-ийн Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэр төслийн барилга угсралтын үе шат явагдаж байгаа бөгөөд аюултай хог хаягдал үүсгэж буй үйл ажиллагаанууд Эрдэнэс Цагаан Суварга ХХК-ийн обьектууд дээр хийгдэж байна. Төслийн талбайд засвар үйлчилгээний төв болон анхан тусламжийн төвөөс аюултай хог хаягдал үүсэж байна. Эдгээр аюултай хог хаягдал үүсэх цэгүүдэд аюултай хог хаягдал түр хадгалах цэгүүдийг байгуулсан.<br>Аюултай хог хаягдлыг 2025 оны 07-р сард өдөр “Түмэн Эгшиг” ХХК-тай 768-1125 гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. |
| 9 | | Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг байршуулж, төслийн талбай дээр түр хадгалан эрх бүхий байгууллагад шилжүүлэх | Үйл ажиллагааны зардал | Мандах сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу хүлээлгэн өгсөн. |
| 10 | Ахуйн болон аюултай хог хаягдал | Хог хаягдлын тоо бүртгэлийг батлагдсан маягт болон “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу тухай бүр хөтөлж, сар бүрийн эцэст дотоод системд бүртгэх, тоо хэмжээг хянах | Үйл ажиллагааны зардал | Хог хаягдлын бүртгэлийг дотоод системд хөтөлж мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласан. |
| 11 | | Компанийн нийт ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлын хэмжээг бууруулах тухай сургалт орох | Үйл ажиллагааны зардал | Улирал бүр нийт ажилчдад хог хаягдлын талаар сургалт зохион байгуулж ажилласан. |
| ***Нийт зардал, төг*** | | | ***6,850,000*** | |

### 9.1.1 Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах

Төслийн талбайд үүсэж буй нийт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг хэрэгжүүлэх нь хог хаягдлын дахин ашиглалт, дахин боловсруулалтыг хэрэгжүүлэх гол үндэс юм. Иймд төслийн талбайн хэмжээнд энгийн хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд буюу ажилчдын кемп, оффис, гал тогоо зэрэг газруудад ангилан ялгалттай хогийн савыг стандарт шаардлагын дагуу байрлуулаад байна.

Тайлант онд үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн хог хаягдлыг дараах 2 төрлөөр ангилан ялгаж байна. Үүнд:

- Дахин ашиглах боломжтой хог хаягдал (Хуванцар, мод, төмөр)
- Дахин ашиглах боломжгүй бусад хог хаягдал




*Зураг 9-1. Төслийн талбайд байршуулсан хогийн савнууд*

### 9.1.2 Дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх

Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусгаарлаж хадгалж байна. /хуванцар, сав/






*Зураг 9-2. Дахин боловсруулах хаягдлыг түр хадгалах цэг*

### 9.1.3 Хог хаягдлын нэгдсэн цэгийн төлөвлөгөө гаргах

Одоогоор ашиглаж буй хог хаягдлын түр хадгалах цэг нь холбогдох хууль, стандартын шаардлагыг хангахгүй, хог хаягдлыг зохих нөхцөлд хадгалах боломжгүй байна. Иймд шинэ хог хаягдлын цэгийг одоо байгаа байгууламжийн хойд талд 30м x 15м талбайтай, 4м өндөр агуулах хэлбэрийн загвараар барихаар төлөвлөж байна.



7. НЭГДСЭН ХОГИЙН ЦЭГИЙН АХИН ТӨЛӨВЛӨЛТ

7.1 Хог хаягдлын цэгийн засварын төлөвлөлт

Одоогоор ашиглаж буй хог хаягдлын түр хадгалах цэг нь холбогдох хууль, стандартын шаардлагыг хангахгүй, хог хаягдлыг зохих нөхцөлд хадгалах боломжгүй байна. Иймд шинэ хог хаягдлын цэгийг одоо байгаа байгууламжийн хойд талд 30м x 15м талбайтай, 4м өндөр агуулах хэлбэрийн загвараар барихаар төлөвлөж байна. Энэхүү байгууламжийн хувьд 3 метр тутамд 3.5 метр өндөртэй шивлэр төмөр багана босгож, каркасыг гагнаж холбох ба ханын дүүргэлтийг блок эсвэл нимгэн төмрөөр хийж, шалыг цементээр цутгах шийдэлтэй байна.

*Зураг 5. Загвар зураг*

Хог хаягдлын цэгийн зохион байгуулалтад 1 ширхэг шатаах зуух, 2 ширхэг хог пресслэх машин, хуванцар, лааз, ахуйн хэрэглээний хог зэргийг төрөлжүүлэн ангилах зориулалт бүхий тасалгаатай хогийн савууд төлөвлөгдөн багтсан.



*Зураг 6. Хог хаягдлын цэгийн ахин төлөвлөлт*

**Пресслэх машин**

ТВ-20Т Маркын хог хаягдал пресслэх зуух тавих бөгөөд энэхүү гидрийн пресслэгч машиныг хаягдал цаас, хуванцар, даавуу гэх мэт бүх төрлийн зөөлөн эдлэлийг шахаж бооно. Мөн оёдлын үйлдвэр, хэвлэх үйлдвэр гэх зэрэг газар хэрэглэж болдог тул хаягдал даавуун материлыг мөн шахах боломжтой

Техникийн үзүүлэлт:

- ✓ Цахилгаан зарцуулалт: 4kw
- ✓ Гадна хэмжээс: 1800 x 1100 x 3150 (мм)
- ✓ Доторх хэмжээ: 1130 x 750 x 1500 (мм)
- ✓ Хэрэглээ: Хаягдал цаас 250 кг
- ✓ Хаягдал хуванцар сав (Бөглөөгүй) 70кг
- ✓ Даавуун материал 150кг

**Ангилан ялгах хогийн сав**

Дахин боловсруулах боломжтой хог хаягдал болон ахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг энэхүү ангилсан хогийн саванд түр хадгалах бөгөөд хогийн савны өндөр нь 1.5м өдөр, 4м өргөнтэй байх юм.

*Зураг 7. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав*

7.2 Засвар хийхэд шаардагдах ажиллах хүч, бараа материал

Төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээт байгууллагуудын ажилтнуудын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор хог хаягдлын хэмжээ эрс өсөөд байна. Үүнтэй уялдан хог хаягдлын менежмент, засвар үйлчилгээний ажлыг нэн даруй эхлүүлж, ашиглалтад оруулах шаардлага тулгарч байна. Иймд төсөл бүрэн ашиглалтад орох хүртэлх хугацаанд үйл ажиллагаа явуулах МАЗ, МПС ХХК болон JHY компаниуд уг засвар үйлчилгээнд шаардагдах тодорхой хэмжээний бараа материал, ажиллах хүчээр дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Засвар үйлчилгээний өмнөх бэлтгэл ажлын хүрээнд одоо байгаа дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг ландфилийн аргаар устгаж талбайг чөлөөлнө.

*Зураг 9-3. Хог хаягдлын цэгийн төлөвлөлт*

### 9.1.4 Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг гэрээт байгууллагад нийлүүлэх

“Төвшин сайхан мөнх” НҮТББ-тай 2025 оны  05-р сарын 02-ны өдөр байгуулсан 010-1125 дугаартай дахивар хог хаягдал нийлүүлэх гэрээг байгуулан хамтран ажиллаж байна.

"Төвшин Сайхан Мөнх НҮТББ"-д хүлээлгэн өгөх дахин боловсруулах боломжтой хог хаягдлууд дараах төрлүүдтэй байна: аккумулятор, хөнгөн цагаан хайрцаг (пошпит) болон бусад

төрлийн хөнгөн цагаан, хаягдал төмөр (200 литрийн сав, нимгэн, зузаан, ган, ширэм), гялгар уут, хуванцар сав (ус, ундааны PET сав болон ахуйн зориулалттай HDPE хуванцар), PVC төрлийн хуванцар (тайлрас), цаас (бор картон хайрцаг, A4 бичгийн цаас), шилэн сав (даршилсан ногооны шил – 980гр, 720гр, 550гр, 510гр, 350гр гэх мэт, дахин ашиглах боломжтой шилэн лонх, сав).
"ОБ Индастриал" ХХК-д хүлээлгэн өгөх хог хаягдалд хаягдал тос багтана.
"Мандах суманд" стандартын дагуу ангилж хүлээлгэн өгөх хог хаягдалд ахуйн хатуу хог хаягдал орж байгаа бөгөөд гэрээнд тусгасан заалтуудын дагуу хүлээлгэн өгнө.



*Зураг 9-4. “Төвшин сайхан мөнх” НҮТББ-тай байгуулсан гэрээ*




*Зураг 9-5. Хог хаягдлыг тээвэрлэх, устгах дараалал*

### 9.1.5 Хоол хүнсний үлдэгдлээр бордоо хийх

Туршилтын зорилго

Ахуйд гардаг хүнсний үлдэгдэл (лууван, төмс, байцаа, алим, гадил, өндөгний хальс, кофены шаар, цайны шаар гэх мэт)-ийг ашиглан байгальд ээлтэй аргаар органик бордоо гарган авах, ингэснээр хог хаягдлыг багасгах болон хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга замыг турших.

Туршилтын зорилтууд

1. Хүнсний үлдэгдэл, хаягдал материалуудыг ялгаж, туршилтад бэлтгэх.
2. 60 литрийн багтаамжтай саванд хүнсний үлдэгдлийг зөв харьцаагаар хольж, чийг, агааржуулалтыг тохируулан хадгалах.
3. Хутгах мод, ус шүршигч, жин хэмжигчийг ашиглан туршилтын явцыг хянах (чийгшил, жин, үнэрийн өөрчлөлт зэргийг ажиглах).
4. Хаягдал материалуудын задралын явц болон компост үүсэх хугацааг тодорхойлох.
5. Гарсан компостын чанарыг үнэлж, ахуйн нөхцөлд хэрэглэх боломжийг тодорхойлох.

Туршилтын ач холбогдол

- Экологийн ач холбогдол: Ахуйн хүнсний үлдэгдлийг дахин ашиглан байгаль орчны бохирдлыг бууруулна.
- Эдийн засгийн ач холбогдол: Худалдан авах бордооны зардлыг хэмнэж, органик хаягдлыг үнэ цэнтэй бүтээгдэхүүн болгон хувиргана.
- Нийгмийн ач холбогдол: Байгаль хамгааллын дадал хэвшил төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулна.

Ашигласан материал

- Үндсэн материал: Хүнсний үлдэгдэл: Лууван, төмс, байцаа, алим, гадил, улаан лоолийн хальс, өндөгний хальс, кофены шаар, цайны шаар
- Нэмэлт материал: 60 литрийн багтаамжтай сав, тагтай хуванцар сав, хутгах мод, жин хэмжигч, ус шүршигч сав, хамгаалалтын бээлий, халад
- Орчны нөхцөл: Сүүдэртэй, салхи бага ордог, чийг багатай газар










*Зураг 9-6. Туршилтанд ашигласан хүнсий үлдэгдэл материал*

### 9.1.6 Бусад хог хаягдлыг устгах

Эрдэнэс Цагаан Суварга ХХК нь төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлыг Дорноговь аймгийн Мандах сумын засаг даргын 2012 оны 10-р сарын 29-ний өдрийн А/87 дугаар Хог хаягдлын цэгийн захирамжаар тогтоосон хог хаягдлын цэгт түр хадгалж байна. Хог хаягдлын цэгийг тохижуулан дахин ашиглах боломжтой хог хаягдал буюу хуванцар савыг тусад нь хадгалж байна.



*Зураг 9-7. Хог хаягдлын түр хадгалах цэг*

### 9.1.7 Төслийн талбайн эргэн тойронд нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах

Ажилчид долоо хоног бүрийн ням гаригт бүх нийтийн орчны цэвэрлэгээ зохион байгуулдаг.



*Зураг 9-8. Орчны цэвэрлэгээ*

### 9.1.8 Аюултай хог хаягдал устгуулах

Аюултай хог хаягдлыг 2025 оны 07-р сард өдөр “Түмэн Эгшиг” ХХК-тай 768-1125 гэрээг байгуулан хамтран ажиллаж байна

БАТЛАВ: “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦЭЛМҮҮН

**0964-1121 ТООТ ГЭРЭЭНД**
**НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ**

2025 оны 07-р сарын ....-ний өдөр № 768с1125 Улаанбаатар хот

**Нэг талаас: “Монголын Алт” (МАК) ХХК** (РД:2095025) /цаашид **“Үүсгэгч”** гэх/, түүнийг төлөөлж Ажил үйлчилгээ, худалдан авалтын газрын захирал Д.Нинжбадгар,

**Нөгөө талаас: “Түмэн эгшиг” ХХК** /цаашид **“Хүлээн авагч”** гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Чинзориг бид нар (цаашид хамтад нь **“Талууд”** гэх) Талуудын хооронд байгуулагдсан 0964-1121 тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ (цаашид **“Үндсэн гэрээ”** гэх)-ний 9.1 дэх заалтыг үндэслэн энэхүү “094-1121 тоот гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ” (цаашид “**Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ**” гэх)-г дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Талууд Үндсэн гэрээний хугацааг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 235-1124 тоот гэрээний дагуу сунгаж байсан ба гэрээний хугацааг дахин сунгаж Үндсэн гэрээнд нэмэлт зохицуулалт оруулахыг харилцан тохиролцсон. Үндсэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний зорилго оршино.
1.2. Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үндсэн гэрээгээр зохицуулна.
1.3. Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ нь Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

**ХОЁР. ҮНДСЭН ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1.1. **Үндсэн гэрээнд дараах өөрчлөлт оруулахыг Талууд харилцан тохиролцов. Үүнд:**
1.1.1. Үндсэн гэрээний 1.3 дахь заалтыг *“Үүсгэгч гэдэгт “Монголын Алт” (МАК) ХХК болон түүний охин, хараат, хамаарал бүхий дор дурдсан компаниудыг хамтад нь ойлгоно. Үүнд:*
*1.3.1. “МАК Цемент” ХХК;*
*1.3.2. “Хүрэн Толгой Коал майнинг” ХХК;*
*1.3.3. “Эрдэнэс цагаан суварга” ХХК;*
*1.3.4. “МАК Аранжин зэс” ХХК;*
*1.3.5. “Трү Ти Ар Си” ХХК;*
*1.3.6. “Аяан хотелс энд ресортс” ХХК;*
*1.3.7. “МАК Ложистик” ХХК;*
*1.3.8. “МАК Геодисковерис” ХХК;*
*1.3.9. “МАК Прайм сервис” ХХК;”* гэж өөрчлөх
1.1.2. Үндсэн гэрээний 3.1-д заасан хугацааг *“Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл байна.”* гэж өөрчлөх.
1.1.3. Үндсэн гэрээний 3.3 дахь заалтыг *“Үүсгэгч нь аюултай хог хаягдал шилжүүлэх тухай хүсэлтээ Хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com и-мэйл хаягаар 5-аас доошгүи хоногиин өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч Үүсгэгчтэй харилцан тохиролцож аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацааг товлоно.”* гэж өөрчлөх.
1.1.4. Үндсэн гэрээний 3.4 дэх заалтыг *“Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг Үүсгэгчийн заасан байршлаас Талуудын харилцан тохиролцож товлосон өдөр, цагт зохих журмын дагуу хүлээн авч өөрийн устгах үйлдвэр рүү тээвэрлэнэ. Хүлээн авагч нь Үүсгэгчээс аюултай хог хаягдлыг хүлээн авах эрх бүхий ажилтныг тусгайлан томилсон байна.”* гэж өөрчлөх.
1.1.5. Үндсэн гэрээний 3.9 дэх заалтыг *“Хүлээн авагч нь Үүсгэгчээс хүлээн авсан аюултай хог хаягдлыг өөрийн, тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Үүсгэгч нь Хавсралт №2-т заасан үнийн дагуу Хүлээн авагчийн гүйцэтгэсэн тээврийн гүйцэтгэлээр тооцоо нийлж тээврийн хөлсийг Хүлээн авагчид төлнө.”* гэж өөрчлөх.
1.1.6. Үндсэн гэрээний 5.1 дэх заалтыг *“Хүлээн авагч нь гэрээгээр тохиролцсон хугацаанд аюултай хог хаягдлыг Үүсгэгчийн хог хаягдал байгаа газраас Төв аймаг, сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших өөрийн аюултай хог хаягдал устгах үйлдвэрт хүргэнэ.”* гэж өөрчлөх.
1.1.7. Үндсэн гэрээний 5.3 дахь заалтыг *“Хүлээн авагч нь хүлээн авсан аюултай хог хаягдлыг тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.”* гэж өөрчлөх.
1.1.8. Үндсэн гэрээний Хавсралт №1-т заасан Химийн хортой бодис хадгалсан хаягдал хуванцар сав дахин боловсруулах үйлчилгээний хөлсний тарифыг энэхүү гэрээний Хавсралт №1-ээр өөрчлөх.

**2.1. Үндсэн гэрээнд дараах нэмэлт зохицуулалт оруулахыг Талууд харилцан тохиролцов. Үүнд:**
2.1.1. Үндсэн гэрээний 4.2.6 дахь хэсэгт *“Хүлээн авагч нь гэрээний хугацаанд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусах тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулан түүний хуулбарыг Үүсгэгчид хүргүүлэх үүрэгтэй.”* гэж нэмэлтээр оруулах.
2.1.2. Үндсэн гэрээний 5.7 дахь заалтад *“Талууд дагалдах бичигт аюултай хог хаягдлын нэршлийг гэрээний Хавсралт №1-т заасан нэршилтэй адилаар бичнэ.”* гэж нэмэлтээр оруулах.
2.1.3. Үндсэн гэрээний 7.7 дахь заалтад *“Хүлээн авагч нь тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдлаас үүдэн Үүсгэгчид хохирол учирвал учирсан хохирлыг үл маргах журмаар арилгана.”* гэж нэмэлтээр оруулах.

**ГУРАВ. БУСАД НӨХЦӨЛ**

3.1 Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ хүчин төгөлдөр болсноор Талуудын хооронд байгуулагдсан Үндсэн гэрээний 1.3, 3.1, 3.3, 3.4, 3.9, 4.2.6, 5.1, 5.3, 5.7, 7.7 дахь заалт болон Хавсралт №1-т Нэмэлт, өөрчлөлт орсонд тооцно.
3.2 Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ нь Талуудын хооронд байгуулагдсан 2021 оны 0964-1121 тоот Үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.
3.3 Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг 3 хувь үйлдэж Үүсгэгч 2 хувь, Хүлээн авагч 1 хувийг хадгалах бөгөөд Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Үүсгэгчийг төлөөлж:**
АҮХАГ-ын Захирал Д.Нинжбадгар

ЭЗГ-ын Ахлах хуульч Б.Жанчив

**Хүлээн авагчийг төлөөлж:**
Гүйцэтгэх захирал Г.Чинзориг

*Зураг 9-9. Аюултай хог хаягдлын гэрээ*

## 9.1.9 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгуулах

Уурхайн анхан тусламжийн төвөөс үүсэж буй эмнэлгийн аюултай хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/505-р тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ын дагуу төслийн талбайд түр хадгалан, Дорноговь аймгийн

Мандах сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан “Эмнэлгийн тусгай хог хаягдлыг устгах гэрээ”-ний дагуу сумын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж байна. Тайлант онд 12кг эмнэлгийн халдвартай хог хаягдал 1.5кг эмнэлгийн хурц үзүүртэй иртэй хог хаягдал үүсэж тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад шилжүүлсэн байна.



**ЭМНЭЛГИЙН ТУСГАЙ ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ ГЭРЭЭ**

2023 он 05 сар 01 өдөр №011-5123 Мандах сум

**Нэг талаас:** "Эрдэнэс цагаан суварга" ХХК /цаашид **"Захиалагч"** гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Цогт,

**Нөгөө талаас:** Дорноговь аймгийн Мандах сумын Эрүүл мэндийн төв /цаашид **"Гүйцэтгэгч"** гэх/, түүнийг төлөөлж дарга Э.Чулуунцэцэг нар харилцан тохиролцож Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 249/201 тоот тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2011 оны 05 сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалыг тус тусыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах Цагаан суваргын уурхайн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байрнаас гарсан тусгай хог хаягдлыг холбогдох дүрэм, журам, стандартын дагуу устгах, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон үнийг Гүйцэтгэгчид төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгон зохицуулна.
1.2 Эмнэлгийн тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах ажлыг стандарт шаардлагын дагуу мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, хог хаягдал түр хадгалах цэг болон хог хаягдал устгаж байгаа орчныг цэвэр байлгахад энэхүү гэрээний зорилго оршино.
1.3 Энэхүү гэрээ нь Хавсралт №1 – "Хог хаягдал хүлээлцэх маягтын загвар"-тай байх бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
1.4 Энэхүү гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ, ХУГАЦАА.**

2.1 Энэхүү гэрээг 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаанд дагаж мөрдөнө.
2.2 Гэрээний хугацаа дуусмагц гэрээг Талууд харилцан тохиролцож шинэчлэн байгуулж болно.
2.3 Гүйцэтгэгчийн ажилтан тусгай хог хаягдлыг устгалд оруулсан тухай бүр тэмдэглэлийг үйлдэх ба Эрүүл мэндийн төвийн даргын хяналт тавигдаж, гарын үсгээр баталгаажсан байна.Тэмдэглэлийн маягтыг гэрээнд хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
2.4 Эмнэлгийн хог хаягдал устгасны 1 сарын төлбөр нь **10,000** төгрөг байна.

**ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ.**

3.1 Гүйцэтгэгч нь тусгай хог хаягдлыг устгах ажлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, норм стандартын шаардлагад бүрэн нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.
3.2 Гүйцэтгэгч нь Захиалагчийн Цагаан суварга төслийн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байрнаас гарсан тусгай хог хаягдлыг стандартын дагуу уут, саванд хийх, устгах хүртэл хадгалах, битүүмжлэх, тээвэрлэх талаар мэргэжлийн зөвлөгөөг Захиалагчийн төлөөлөгчид өгөх үүрэгтэй.
3.3 Гүйцэтгэгч нь Захиалагчийн Цагаан суварга төслийн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх байрнаас хүргэгдэн ирсэн тусгай хог хаягдлыг технологийн дагуу хүлээн авч хадгалсан сав, баглаа боодлын стандарт шаардлагад хяналт тавьж, шаардлага хангасан тохиолдолд хүлээн авна.
3.4 Тусгай хог хаягдлыг стандартын дагуу устгаж, устгал хийсэн тухай тэмдэглэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөн баталгаажуулсан 1 хувийг Захиалагчийн Цагаан суварга төслийн эмнэлгийн эмчид тухай бүр нь хүргүүлнэ.
3.5 Гүйцэтгэгч нь тусгай хог хаягдал устгасны төлбөрийн нэхэмжлэхийг улирал тутамд Захиалагчид хүргүүлнэ.
3.6 Гүйцэтгэгч нь тусгай хог хаягдлыг устгах ажлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа

011-5123 тоот гэрээний хавсралт №1

Хог хаягдал хүлээлцэх маягтын загвар

| Хог ачиж тээвэрлэсэн огноо | Тээврийн хэрэгслийн марк, тээврийн хэрэгслийн дугаар | Хог хаягдлын жин /кг/ | | | | Хүлээлгэн өгсөн хүний нэр, гарын үсэг | Хог устгасан байгууллага гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шар уутгай хог | Улаан уутгай хог | Аюулгүйн хайрцаг | Хүрэн уутгай хог | | |

**ХАВСРАЛТ БАТАЛГААЖУУЛСАН:**

Захиалагчийг төлөөлж:
Цагаан суварга уурхайн дарга
Ашиглалтын өмнө захирганы дарга Б.Мөнгөнжолоо ..................

Гүйцэтгэгчийг төлөөлж:
Мандах сумын Эрүүл мэндийн төвийн
Дарга Э.Чулуунцэцэг ..................

3

*Зураг 9-10. Эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээ*

Аюултай хог хаягдлыг 2025 оны 07 сарын 25, 09 сарын 18 ны өдрүүдэд 13 кг халдвартай хог хаягдал 1.5 кг хурц үзүүртэй хаягдал, 2 ш бохирдсон хайрцаг хүлээлгэн өгч ажилласан. Эмнэлгийн хаягдлын тусгаарласан хайрцагт хүлээлгэн өгөхөөс өмнө түр хадгалдаг.



HENGYUAN GROUP

Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаал 2017 оны 12 сарын 12 өдрийн А/505 тушаал

**Монгол дахь Хэнг Юань зэсийн уурхайн төслийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх нэгжийн хог хаягдал устгуулсан тухай акт**

**恒远蒙古铜矿项目门诊废物处理登记表**

Эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах , устгах байгууламжид хүлээлгэн өгөх бүртгэлийн маягт

2025 он 09 сар 18 өдөр

Тээврийн хэрэгслийн дугаар: 47-31 УБН. Жолоочийн нэрг, утас: Б. Ариунболд 88184416.

| Эрүүл мэндийн байгууллагын нэр | Халдвартай хог хаягдал /кг / | Хурц үзүүртэй иртэй хог хаягдал /кг / | Эмгэг хог хаягдал | Эмийн болон эсэд хортой хог хаягдал | Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг | Хүлээн авсан хүний гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|
| Дорноговь. Чойжин бүлэг ЭМТ | 1кг | 1кг. | | | Батчулуун | [illegible] |
| | | | | | | |

*Зураг 9-11. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгсөн акт*



*Зураг 9-12. Эмнэлгийн хог хаягдал түр хадгалах цэг*

# БҮЛЭГ 10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Цагаан суваргын катодын зэсийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Төслийн хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг дотоод хяналт шинжилгээ, гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээ гэсэн 2 хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөлөсөн.

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр: Байгаль орчны мэргэжилтэн бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор төслийн талбайд агаар, дуу чимээ, цаг уурын хяналт шинжилгээг улиралд 1 удаа, ургамал амьтны судалгааг жилд 1 удаа байхаар хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэв.
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр: Хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулалт хийсэн.

*Хүснэгт 10-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 8 |
| | | *Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр* | | | | | |
| 1 | **Цаг уур**<br>• Агаарын температур<br>• Хур тунадас<br>• Салхины хурд, чиглэл | Цаг уурын станц | Сар бүр | 12 | Үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны зардал | MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн шаардлага |
| 2 | **Дуу чимээ** | • SXEW_N_1 (Оффис)<br>• SXEW_N_2 (Баяжуулах үйлдвэр)<br>• SXEW_N_3 (УХЗ-ын хажууд)<br>• SXEW_N_4 (Нуруулдан уусгах талбайн баруун талд)<br>• SXEW_N_5 (Нуруулдан уусгах талбайн зүүн талд)<br>• SXEW_N_6 (Дотоод тээврийн замын хажууд) | Сар бүр | 12 | Үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны зардал | |
| 3 | **Ус**<br>• Усны статистик түвшин | • SXEW_GW_1<br>• SXEW_GW_2<br>• SXEW_GW_3 | Сар бүр | 12 | Үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны зардал | MNS ISO 5667:11:2001. Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний |

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | • SXEW_GW_4<br>• SXEW_GW_5 | | | | | усснаас дээж авах зөвлөмж MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ |
| 4 | **Ургамлан нөмрөг**<br>• Ургамлын зүйлийн бүрдэл<br>• Ургамлын нөмрөгийн бүрхэц | • SXEW_P_1 (Нуруулдан уусгах талбайн баруун талд)<br>• SXEW_P_2 (Нуруулдан уусгах талбайн баруун хойно)<br>• SXEW_P_3 (Шимт уусмалын сангийн баруун хойно)<br>• SXEW_P_4 (Баяжуулах үйлдвэрийн хойно)<br>• SXEW_P_5 (Нуруулдан уусгах талбайн зүүн талд) | Вегетацийн үед (8-р сард) | 1 | Үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны зардал | Батлагдсан арга зүйн дагуу |

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | **Амьтны аймаг**<br>• Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг<br>• Амьтдын тоо толгой | • SXEW_AL_1<br>• SXEW_AL_2<br>• SXEW_AL_3<br>• SXEW_AL_4 | Жилд 1-2 удаа | 1-2 | Үйл ажиллагааны зардал | Үйл ажиллагааны зардал | |
| ***Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр*** | | | | | | | |
| 1 | **Агаарын чанар**<br>• Орчны тоосжилт ($PM_{10}$, $PM_{2.5}$, TSP)<br>• Хүхэрлэг хий<br>• Азотын давхар исэл | • SXEW_A_1 (Оффис)<br>• SXEW_A_2 (Баяжуулах үйлдвэрийн баруун талд)<br>• SXEW_A_6 (Нуруулдан уусгах талбайн урд талд)<br>• SXEW_A_8 (УХЗ, склад хоёрын дунд)<br>• SXEW_A_9 (Нуруулдан уусгах талбайн баруун талд)<br>• SXEW_A_10 (Дотоод тээврийн замын хажууд) | Улирал бүр | 4 | 47,000 | 47,000*6*4= 1,128,000 | MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн шаардлага |
| 2 | **Дуу чимээ** | • SXEW_N_1 (Оффис)<br>• SXEW_N_2 (Баяжуулах үйлдвэр)<br>• SXEW_N_3 (УХЗ-ын хажууд) | Улирал бүр | 4 | 25,000 | 25,000*6*4= 600,000 | |

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | • SXEW_N_4 (Нуруулдан уусгах талбайн баруун талд)<br>• SXEW_N_5 (Нуруулдан уусгах талбайн зүүн талд)<br>• SXEW_N_6 (Дотоод тээврийн замын хажууд) | | | | | |
| 3 | **Хөрс**<br>• pH<br>• Ялзмаг<br>• Механик бүрэлдэхүүн<br>• Аммонийн азот, нитратын азот, фосфор, сульфат<br>• Хүнд металлууд<br>• Нефтийн бүтээгдэхүүн | • SXEW_S_1 (Нуруулдан уусгах талбайн баруун урд)<br>• SXEW_S_3 (Шимт уусмалын сангийн баруун хойно)<br>• SXEW_S_4 (Баяжуулах үйлдвэрийн баруун талд)<br>• SXEW_S_6 (УХЗ-ын зүүн хойно)<br>• SXEW_S_7 (Дотоод тээврийн замын зүүн талд) | Улирал бүр | 4 | 173,500 | 173,500*5*4= 3,470,000 | MNS 2305:1994. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам<br>MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| ***Нийт, төг*** | | | | | ***5,198,000*** | | |

*Хүснэгт 10-2. Орчны хяналт мониторингийн цэгүүдийн тайлбар*

| № | Нэр | Код | Хяналт шинжилгээний төрөл | Өргөрөг UTM | Уртраг UTM | Тайлбар | Ач холбогдол |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Усны хяналт мониторингийн цэгүүд** | | | | | | | |
| 1 | Төслийн талбайн зүүн хойно 2.5км | SWEX_GW_1 | Ус | 290063 | 4862697 | Статик түвшин | Төслийн талбайн ойр орчмын уст цэгийн мэдээллийг тогтмол бүртгэх, дата мэдээлэл үүсгэсэн, |
| 2 | Төслийн талбайн зүүн хойно 1.7км | SWEX_GW_2 | Ус | 289995 | 4862113 | | |
| 3 | Төслийн талбайн зүүн хойно 1.67км | SWEX_GW_3 | Ус | 290002 | 4861833 | | |
| 4 | Төслийн талбайн зүүн хойно 1.5км | SWEX_GW_4 | Ус | 289823 | 4861829 | | |
| 5 | Төслийн талбайн зүүн хойно 1.6км | SWEX_GW_5 | Ус | 289931 | 4861571 | | |
| **Хөрсний хяналт мониторингийн цэгүүд** | | | | | | | |
| 1 | Нуруулдан уусгах талбайн баруун урд | SWEX_S_1 | Хөрс | 287508 | 4861059 | Ялзмаг,Хөрсний хими болон физик шинж чанар, хүнд металлын шинжилгээ хийж гүйцэтгэнэ. | Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үүсч буй сөрөг нөлөөллийг тогтоох, цаашид авах хэмжээг төлөвлөх, дата мэдээлэл үүсгэв. |
| 2 | Шимт уусмалын сангийн баруун хойно | SWEX_S_3 | Хөрс | 287858 | 4861721 | | |
| 3 | Баяжуулах үйлдвэрийн баруун талд | SWEX_S_4 | Хөрс | 288092 | 4861540 | | |
| 4 | УХЗ-ийн зүүн хойно | SWEX_S_6 | Хөрс | 288221 | 4861594 | | |
| 5 | Дотоод тээврийн замын зүүн талд | SWEX_S_7 | Хөрс | 288347 | 4860704 | | |
| **Агаарын хяналт мониторингийн цэгүүд** | | | | | | | |
| 1 | Оффис | SWEX_A_1 | Агаар | 288184 | 4861647 | Тоосжилт PM 2.5, PM 10.0 TSP, $SO_2$, CO, $NO_2$ | Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд үүсч буй сөрөг |
| 2 | Баяжуулах үйлдвэрийн баруун талд | SWEX_A_2 | Агаар | 288099 | 4861588 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Нуруулдан уусгах талбайн урд талд | SWEX_A_6 | Агаар | 287988 | 4861452 | хэмжилт хийгдэнэ | нөлөөллийг үнэлэх, тоосжилт бууруулах арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулах, дата мэдээлэл бүрдүүлсэн. |
| 4 | УХЗ, склад хоёрын дунд | SWEX_A_8 | Агаар | 288221 | 4861452 | | |
| 5 | Пүү | SWEX_A_9 | Агаар | 288294 | 4861597 | | |
| 6 | Дотоод тээврийн зам дагуу-3 | SWEX_A_10 | Агаар | 287441 | 4860971 | | |
| **Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд** | | | | | | | |
| 1 | Оффис | SWEX_N_1 | Дуу чимээ | 288189 | 4861652 | Дуу чимээний хүлцэх түвшинг хэмжинэ | Дуу чимээнээс үүсч буй сөрөг нөлөөллийг үнэлэх, цаашид авч арга хэмжээг төлөвлөх, дата мэдээлэл үүсгэв. |
| 2 | Баяжуулах үйлдвэр | SWEX_N_2 | Дуу чимээ | 288100 | 4861592 | | |
| 3 | УХЗ-ны хажууд | SWEX_N_3 | Дуу чимээ | 288225 | 4861553 | | |
| 4 | Нуруулдан уусгах талбайн баруун талд | SWEX_N_4 | Дуу чимээ | 287544 | 4861271 | | |
| 5 | Дотоод тээврийн замын хажууд | SWEX_N_6 | Дуу чимээ | 288032 | 4860732 | | |
| **Ургамлын хяналт мониторингийн цэгүүд** | | | | | | | |
| 1 | Нуруулдан уусгах талбайн баруун талд | SWEX_P_1 | Ургамал | 287518 | 4861225 | Ургамалын бичиглэл хийгдэнэ | Төслийн үйл ажиллагаанаас ургамалд үзүүлж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, төслийн талбайн ойр орчмын ургамалжилтыг бүртгэж дата мэдээлэл үүсгэв. |
| 2 | Шимт уусмалын сангийн баруун хойно | SWEX_P_3 | Ургамал | 287882 | 4861817 | | |
| 3 | Баяжуулах үйлдвэрийн хойно | SWEX_P_4 | Ургамал | 288141 | 4861758 | | |
| 4 | Төслийн талбайн зүүн талд 2.6км | SWEX_P_6 | Ургамал | 291098 | 4861595 | | |

### 10.1.1 Цаг уурын хяналт шинжилгээ

Төслийн талбай орших Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар мужид багтах бөгөөд Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их 33.6$^0$C, өвөлдөө хүйтэн боловч зундаа аагим халуун байдаг.

Цагаан суваргын төслийн талбайд 2012 онд Campbell брэндийн CR-1000 загварын цаг уурын автомат станц суурилуулж, 2013 онд УЦУОШГ-аар баталгаажилт хийлгэсэн байдаг. Тус цаг уурын станц нь 2013 оны 04-р сарын 11-ны хүртэл хэвийн ажиллаж байгаад тэжээлийн эх үүсвэрийн тасалдлын улмаас ажиллагаагүй байсныг 2024 оны 03-р сарын 11-ны өдөр гэрээт байгууллагаар засвар үйлчилгээг хийлгэн, хэвийн үйл ажиллагаанд оруулаад байна. Цаг уурын автомат станц нь дараах иж бүрдлээс бүрдэж байна. Үүнд:

- Салхины чиглэл, хурдны мэдрэгч – RMYOUNG 05103
- Агаарын температур – 109 L
- Агаарын температур, чийгийн мэдрэгч – HMP35V
- Хур тунадасны мэдрэгч – TE525
- Нарны цацрагийн балансын мэдрэгч – NR-LITE2
- Нарны зайн хавтан - 30W
- Аккумляторын батарей – 12V
- Даталоггер – CR1000
- Компьютерт холбох зориулалт бүхий кабель – RS232

Цаг уурын станцыг хувийн үйл ажиллагаанд оруулсны дараа БОМТ-д тусгасны дагуу сар бүр цаг уурын үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэж байна.

*Хүснэгт 10-3. Төслийн цаг уурын станцын байрлал*

| *№* | *Цэгийн нэр* | *Цэгийн координат* | *Хяналт мониторингийн ач холбогдол, давтамж* |
|---|---|---|---|
| 1 | CR-1000 цаг уурын станц | 49 U 286084 UTM 4861774 | Цаг уурын үзүүлэлтүүд буюу салхины чиглэл, хурд, агаарын температур, чийг, хур тунадас, нарны цацраг зэргийг хянах зорилготой 24 цагийн станц бөгөөд сар бүр датаг нэгтгэн авна. |

**Цаг уурын хяналт шинжилгээний цэг**




*Зураг 10-1. Цаг уурын хяналт мониторингийн цэг*

## Агаарын температур

Төслийн талбайн агаарын температурын хэмжилтийн үр дүнгээс үзэхэд агаарын дундаж температур 3-р сард 3.15$^0$C, 4-р сард 10.97$^0$C, 5-р сард 19.22$^0$C, 6-р сард 23.09$^0$C, 7-р сард 25.84$^0$C, 8-р сард 23.8$^0$C, 9-р сард 16.38$^0$C байсан байна. Цаг уурын станцын сар болон өдрийн дундаж температурын харьцуулалтыг доор тусгав.

*Хүснэгт 10-4. Сарын дундаж агаарын температур*

| № | Үзүүлэлт | Сар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | III | IV | V | VI | VII | VIII | IX |
| 1 | $T_{max}$ | 10.52 | 17.63 | 26.86 | 29.7 | 32.23 | 29.41 | 22 |
| 2 | $T_{min}$ | -4.21 | 4.31 | 11.58 | 16.48 | 19.46 | 18.19 | 10.76 |
| 3 | $T_{mean}$ | 3.15 | 10.97 | 19.22 | 23.09 | 25.84 | 23.8 | 16.38 |




*График 10-1. Агаарын дулаан хүйтний сарын явц*















*Зураг 10-1. Сар бүрийн агаарын температур*

**Хур тунадасны горим**

Төслийн талбайн ойр орчимд 2025 оны 10-р сарын байдлаар 117.088 мм хур тунадас унасан бөгөөд түүний ихэнх хувь нь дулааны улиралд буюу 7-9 сарын хооронд орсон байна. Сар бүр унасан нийлбэр хур тунадасны хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 10-5. Сарын нийлбэр хур тунадас*

| *№* | *Үзүүлэлт* | *Сар* | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *III* | *IV* | *V* | *VI* | *VII* | *VIII* | *IX* |
| *1* | Хур тунадас (мм) | 0 | 0.508 | 11.94 | 3.048 | 35.56 | 65.53 | 0.508 |




*График 10-2. Сарын нийлбэр хур тунадасны явц*

**Агаарын чийгшлийн горим**

Агаар усны уураар ханах төлөвтөө хир зэрэг дөхөж байгааг илэрхийлэх үзүүлэлт бол харьцангуй чийгшил юм. Тэгвэл нэгж эзлэхүүнтэй агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээг граммаар илэрхийлснийг үнэмлэхүй чийгшил гэнэ. Төслийн талбай орчимд нэн хуурай уур амьсгалтай буюу жилийн дундаж харьцангуй чийгшлийн утга хэлбэлзэл ихтэй, өвлийн улиралд агаар хөрж, улмаар усны уурыг агуулах чадвар буурснаар (агаар шахагдах) ханасан төлөвтөө ойртох учраас харьцангуй чийгшил хамгийн их хэмжээндээ хүрэх ба хавар дулаарснаар (агаар тэлж) агаарын усны уурыг агуулах чадвар нэмэгдээд ирэх үед хамгийн хуурай болох учир харьцангуй чийгшлийн хамгийн бага утга 25-35% болсон байна. Харин зун хур бороону улирал эхлэхээр дахин бага зэрэг нэмэгдээд, намар эргээд буурах хэдий ч хүйтрэлт эхлэхэд агаар шахагдсанаар намрын сүүл сард өссөн байна.

*Хүснэгт 10-6. Агаарын чийгшлийн үзүүлэлт*

| *№* | *Үзүүлэлт* | *Сар* | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *III* | *IV* | *V* | *VI* | *VII* | *VIII* | *IX* |
| *1* | Харьцангуй чийгшил ($RH_{max}$) | 55.15 | 47.17 | 41.19 | 49.96 | 66.77 | 72.60 | 79.11 |
| *2* | Харьцангуй чийгшил ($RH_{min}$) | 14.56 | 14.94 | 10.16 | 14.80 | 21.60 | 25.56 | 31.02 |
| *3* | Харьцангуй чийгшил ($RH_{mean}$) | 34.85 | 31.05 | 25.67 | 32.38 | 44.18 | 49.08 | 55.06 |

**Салхины хурд, чиглэл**

Нарны цацраг дэвсгэр гадаргад ирээд зарим хэсэг нь буцаж ойдог бол зарим хэсэг нь түүнд шингэснээр дулааны энергид шилжинэ. Дэвсгэр гадаргын жигд бус байдлаас болоод гадарга мөн харилцан адилгүй халж, улмаар агаарын даралтын жигд бус хуваарилалт бий болно. Даралт ихтэй (хүйтэн) газраас багатай (дулаан) руугаа хэвтээ чиглэлийн дагуу шилжих агаарын урсгалыг салхи гэнэ.

*Хүснэгт 10-7. Салхины дундаж хурд*

| **№** | **Үзүүлэлт** | **Сар** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **III** | **IV** | **V** | **VI** | **VII** | **VIII** | **IX** |
| *1* | Дундаж салхины хурд, м/с | 27.45 | 34.1 | 33.71 | 29.54 | 25.02 | 22.5 | 25.43 |




*График 10-3. Салхины чиглэлийн давтагдал 3-9-р сар*

## 10.1.2 Дуу чимээний хяналт шинжилгээ

Хүрээлэн буй орчинд үүсэж буй дуу шуугианы түвшин тодорхой стандарт хэмжээнээс давсан тохиолдолд хүний эрүүл мэндэд болон зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг тул төслийн талбай болон түүний ойр орчимд хяналт шинжилгээг явуулан ажиллаж байна. 2025 оны БОМТ-ний дагуу 5 цэгт дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэлээ.

*Хүснэгт 10-8. Төслийн дуу шуугианы хяналт мониторингийн цэгүүд*

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр | Цэгийн координат | Хяналт мониторингийн ач холбогдол, давтамж |
|---|---|---|---|---|
| *1* | SXEW_S_1 | Оффис | 49 U 288189 UTM 4861652 | Дуу чимээнээс үүсэж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, арга хэмжээ төлөвлөх, дата мэдээлэл үүсгэх зорилгоор жилд 1 удаа |
| *2* | SXEW_S_2 | Баяжуулах үйлдвэр | 49 U 288100 UTM 4861592 | |
| *3* | SXEW_S_3 | УХЗ-ны хажууд | 49 U 288225 UTM 4861553 | |
| *4* | SXEW_S_4 | Нуруулдан уусгах талбайн баруун талд | 49 U 287544 UTM 4861271 | |
| *5* | SXEW_S_6 | Дотоод тээврийн замын хажууд | 49 U 288032 UTM 4860732 | |

## Дуу чимээний хяналт шинжилгээний цэг




*Зураг 10-2. Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд*



*Зураг 10-3. Дуу чимээний хэмжилт*

*Хүснэгт 10-9. Дуу чимээний хэмжилтийн үр дүн*

| № | Цэгийн дугаар | Цэгийн нэр | Дуу чимээ ДБА |
|---|---|---|---|
| 1 | SXEW_S_1 | Оффис | 42 |
| 2 | SXEW_S_2 | Баяжуулах үйлдвэр | 50 |
| 3 | SXEW_S_3 | УХЗ-ны хажууд | 51 |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | SXEW_S_4 | Нуруулдан уусгах талбайн баруун талд | 35 |
| **5** | SXEW_S_6 | Дотоод тээврийн замын хажууд | 42 |
| **MNS4585:2016** | | | **60** |

### 10.1.3 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг сөрөг нөлөөлөл үүсгэж болохуйц ажлын талбаруудаас хамаарч агаарын чанарын нийт 6 цэгт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар дах тоос тоосонцор (TSP, PM10, PM2.5), хүхэрлэг хий (SO2), азотын давхар ислийн (NO2) агууламжийг жилийн турш төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

*Хүснэгт 10-10. Агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд*

| *№* | *Цэгийн дугаар* | *Цэгийн нэр* | *Цэгийн координат* | *Дээж авсан цэгийн тодорхойлолт* |
|---|---|---|---|---|
| *1* | SWEX_A_1 | Оффис | 49 U 288184 UTM 4861647 | Төслийн үйл ажиллагаанаас агаарын орчинд үүсэж буй сөрөг нөлөөллийг үнэлэх, тоосжилт бууруулах арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулах, дата мэдээлэл үүсгэх |
